

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Хувь
МУ-ын хууль					
1	1	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01	15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах;	Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 55.4 тэрбум төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, 78 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрх төсөл арга хэмжээнээс бүс нутгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв", "Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ, авто замын ажил"-ууд, Шаамар, Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур чиглэлийн 128 км зам, Орхон, Хараа голын гүүрний ажил, хүлэмжийн аж ахуйг дэмжсэн төслүүд амжилттай хэрэгжсэн. Мөн аймгийн төв Сүхбаатар суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 50 мВт-ын дулааны цахилгаан станцыг барихаар Техник эдийн засгийн үнэлгээг батлуулан, шавь тавих үйл ажиллагааг зохион байгуулсан.	70%
	2		15.2.4. бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;	Бүс нутгийн хөгжлийн талаар Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ, шийдвэрүүдийн талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг дарга нарт танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг өгч, хамтран ажиллаж байна.	70%
	3		7.4. Нийслэлийнхээс бусад Зөвлөлийн даргын бүрэн эрхийг тухайн бүсэд багтах аймгийн Засаг дарга нараас үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсон аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.	"Төвийн бүсэд Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгууд хамаардаг. Эдгээр аймгийн Засаг дарга нараас зөвлөлийн даргыг өнөөдрийн байдлаар томилоогүй байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	30%
2	4	Өрийн удирдлагын тухай 2015-02-18 Дугаар 2015.02.15	28.1.7. Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газар баталж мөрдүүлнэ.	Үнэт цаас гаргаагүй. /Цаашид хяналтаас хасуулах саналтай./	100%
3	5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй	18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны I хурлаар 2023 онд хийж хэрэгжүүлэх 4 бүлэг 41	100%

	тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	ажил, арга хэмжээ бүхий төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталж, хэрэгжилт 87 хувьтай зохион байгуулж ажилласан.	
6		18.1.2. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуваарилсан 12.0 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч 1 хамтарсан багт 300.0 мянган төгрөгөөр тооцон хуваарилан хүргүүлж зарцуулалтад хяналт тавин ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр “Миний оролцоо”, “Яг одоо”, “Гэгээн өдөр”, “Хүүхэд бүр инээж байг”, соён гэгээрүүлэх арга хэмжээ, аяныг зохион байгууллаа.	100%
7		18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	2023 онд Мандал, Алтанбулаг сумын түр хамгаалах байраар нийт 36 хүүхэд, 5 насанд хүрэгч нийт 41 иргэнд 324 өдрийн үйлчилгээ үзүүлээ. Мандал суманд Азийн хөгжлийн банкны 3.7 сая төгрөгийн санхүүжилтээр сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх өрөө, эмчийн үзлэгийн өрөөг сайжруулан тохижуулсан. Алтанбулаг сум дахь түр хамгаалах байрыг 2023 оны 10 дугаар сард Цагдаагийн газрын дэргэдэх Азийн хөгжлийн банк, "Японы ядуурлыг бууруулах сан"-ийн санхүүжилтээр байгуулсан “Хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” төвд шилжүүлсэн бөгөөд тус байрны үйл ажиллагааг нь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хамгаалалтыг Цагдаагийн газар, үйл ажиллагааны зардлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцахаар зохицуулалт хийн үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Тус байрны үйл ажиллагаанд 2023 онд орон нутгийн төсвөөс нийт 6,5 сая төгрөг зарцуулсан. Ерөө сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Түр хамгаалах байр" барих ажилд 80 сая, үйл ажиллагааны зардалд 20 сая төгрөгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлсэн.	100%
8		19.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг 43 удаа зохион байгуулж төрийн байгууллагын 1381 ажилтан албан хаагч,	100%

		сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын 6418 эцэг, эх нийт 7799 иргэдийг хамруулсан. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай", "Гэр бүлийн тухай" хуулийг сурталчилсан 31 удаагийн сургалтад нийт 1410 иргэдийг хамрууллаа. "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сургалтыг төрийн байгууллагын 149 ажилтан, албан хаагч ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 350 эцэг, эх нийт 499 иргэнд зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 2022 онд 525, 2023 онд 513 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 буюу 2 хувиар буурсан байна.	
	9	19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл зохион байгуулж сургалтад хамрагдсан албан хаагчдад хөтөлбөрийн дагуу "Кейс менежментийн үе шат болоод шат бүрд анхаарах зүйл, кейс шийдвэрлэлтийн явцад гаргадаг алдаа, кейсийн бүрдэл, баримтжуулах нь" зэрэг сэдвүүдээр хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө "Галт шувуу холбоо" ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Дуламсүрэн хичээл заасан. Сургалтад нийт 40 хамтарсан багийн төлөөлөл болох 50 албан хаагч хамрагдлаа. Мөн Монгол Улсад ГХУСА33-ийн Ажлын алба, "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-тэй хамтран аймгийн хэмжээний хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2023 оны 09 сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулж, хамтарсан багийн 205 гишүүнийг хамрууллаа.	100%
	10	19.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Ерөө сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Түр хамгаалах байр" барих ажилд 80 сая, үйл ажиллагааны зардалд 20 сая төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлж ажилласан. Түр хамгаалах байрны зардал болох тогтмол болон урсгал зардал 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 142 дугаар тогтоолоор 120.1 сая төгрөгийн төсөв батлагдсан. Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжид 9,1 сая төгрөг, Албан хаагчдын ажиллах орчныг сайжруулахад шаардлагатай хөрөнгөд 14.5 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын захирамжаар дэмжлэг болон санхүүжүүлсэн байна.	70%
	11	19.1.4. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж,	Аймгийн Засаг даргын А/41 дүгээр захирамжаар 2022-2024 онд хэрэгжүүлэх "Архигүй Сэлэнгэ" арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллалаа. 2023 онд сум бүр "Архигүй сум, баг" аяныг өрнүүлсэн бөгөөд Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 77 дугаар тогтоолоор "Тайван Сүхбаатар" дэд хөтөлбөрийг батлан, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 4.8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, "Аз жаргалтай гэр бүл, амар тайван хот" зорилтыг тусган уг зорилтын хүрээнд сургалт, хэлэлцүүлгийг зохион	100%

		иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	байгуулж орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 30 байгууллага аж ахуйн нэгжийн удирдлагуудад зөвлөмж хүргүүллээ. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд нийт 563 эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж, 365 ширхэг гарын авлага тараасан. Ерөө сум нь сургуулийн гаднах авто зогсоол шинээр барих, цэцэрлэгийн авто зогсоол засварлах 1 тэрбум төгрөгийг батлуулан, уг зогсоолыг ашиглалтад орууллаа.	
12		19.1.5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 17 сумын 40 хамтарсан багт үйл ажиллагааг нь дэмжиж тус бүр 300.000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хамтарсан багт Алтанбулаг сум 1 сая, Ерөө сум 100 сая, Сант сум 1,5 сая, Сүхбаатар сум 27 сая, Хүдэр сум 10 сая, Зүүнбүрэн сум 10 сая, Хушаат сум 2 сая 565 мянга, Түшиг сум 2 сая нийт 154,0 сая төгрөгийг батлуулан дэмжлэг үзүүлсэн.	100%
13		19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Мандал сумын түр хамгаалах байранд Азийн хөгжлийн банкны 3.7 сая төгрөгийн санхүүжилтээр сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх өрөө, эмчийн үзлэгийн өрөөг тохижуулсан. "Насанд хүрээгүй хохирогч хүүхдээс мэдүүлэг авах өрөө"-г ДЗМОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөртэй хамтран 13.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар байгуулсан. Тус өрөөгөөр дамжуулан аливаа мөрдөн шалгах ажиллагаа явагдах үед хохирогч хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангаж ажиллаж байна.	70%
14		19.1.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагууд Дэлхийн зөн Олон улсын байгууллага, Европын холбооны дэмжлэгтэйгээр "Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё" төслийг хэрэгжүүлсэн. Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах 8 удаагийн сургалт зохион байгуулагдахад Улаанбаатар хотын 43, Сүхбаатар сумын 6 байгууллага хамрагдаж, хүүхэд хамгааллын чиглэлээр хамтран ажиллаж "Миний биеийн аюулгүйн дүрэм", "Өөртөө итгэлтэй хүүхэд ба хүчирхэг хөвгүүд охид", "Аавын цаг" цуврал сургалтуудыг зохион байгуулж, "Амлая" нөлөөллийн аяныг амжилттай зохион байгуулсан.	100%

			“Анбаунд Монгол” ТББ-тай хамтран “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 745, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 455, нийт 1200 сурагчдад, залуучуудын хууль, эрх зүйн боловсролын нэмэгдүүлэх чиглэлээр “Залуучуудын оролцоо, манлайлал” сэдэвт сургалтыг “JCI Mongolia” олон улсын байгууллага болон “Илтгэх индрийн ирээдүй” ТББ-тай хамтран тус тус зохион байгуулан ажилласан.	
15		19.1.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	“Тайван Сүхбаатар” дэд хөтөлбөрийн хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, архины зохисгүй хэрэглээнээс үүдэн гарах гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор “Архигүй хамт олон, баг” аяныг зохион байгуулсан. Уг аянд төр, төсвийн байгууллага, төрийн албан хаагчид, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хувьцаат компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, томоохон аж ахуй нэгжүүдийг хамруулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 320 гаруй сурагчдыг хамруулан “Архи бидний ирээдүй биш” сургалтыг 6 удаа зохион байгуулсан. Хүдэр сумын 3 төрийн бус байгууллага, 34 иргэнийг хамруулсан бөгөөд архинаас гараад 2-18 жил болсон 3 иргэнээс ярилцлага авч архины хор, хөнөөлийн талаарх иргэдийн сэтгэгдлийг олон нийтэд түгээх зэргээр зохион байгууллаа.	100%
16		25.2. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.	Сэлэнгэ аймгийн суурин хүн амын тоо 107899. Аймгийн Цагдаагийн газар нь Удирдлага, Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шуурхай удирдлагын тасаг, Ерөө сумын цагдаагийн тасаг, Алтанбулаг сумын цагдаагийн хэсэг, Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс (хэлтэс дотроо Удирдлага, Захиргааны удирдлагын хэсэг, Эрүүгийн цагдаагийн хэсэг, Мөрдөн байцаах хэсэг, Нийтийн хэв журам хамгаалах хэсэг) Баянгол сумын цагдаагийн хэсэг, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс (хэлтэс дотроо Удирдлага, Эрүүгийн цагдаагийн хэсэг, Нийтийн хэв журам хамгаалах хэсэг) гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна. Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтсийн хамгаалалтын цагдаагийн 1 орон тоог тус хэлтэст “Хүний нөөцийн хэрэг хөтлөгч” болгон өөрчлөх саналыг Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөцийн хэлтэст 2023 оны 44/1-2042 дугаартай албан бичгээр хүргүүлж, мөн хэлтсийн зохицуулагчийн 2 орон тооны 1-ийг ахлах зохицуулагч болгох саналыг Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанд 2023 оны 44/1-2982 дугаартай албан бичгээр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн багийн цагдаагийн 3	100%

				орон тоог хэсгийн байцаагч болгох саналыг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд тус тус уламжилснаар багийн цагдаагийн 1 орон тоог хэсгийн байцаагч болгон өөрчлүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн харьяанд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах 1, мэргэжилтэн 2, хүүхдийн асуудал хариуцсан ахлах 1, мэргэжилтэн 2 нийт 6 албан хаагч ажиллаж байна.	
4	17	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	"Төрийн албаны тухай" хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн, хөгжлийн өөрчлөлт, нөхцөл байдалд уян хатан ханддаг, идэвхтэй, санаачилгатай, ёс зүйтэй бөгөөд манлайлагч төрийн албан хаагч, суралцагч байгууллага бүхий төрийн албыг орон нутагт төлөвшүүлэх зорилтын хүрээнд ажил, арга хэмжээг хэрэгжүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. Төрийн зорилт чиг үүргийг чанартай, шуурхай хэрэгжүүлэх үүднээс төрийн албан хаагчийн ажиллах таатай орчин, урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгоход чиглэгдсэн хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн 2018-2024 он хүртэл хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа" аймгийн хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хөтөлбөрийн төлөвлөгөө нь 5 зорилтын хүрээнд 27 ажил, арга хэмжээг хэрэгжүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2023 оны 2 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, 17 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, 57 багийн Засаг дарга нарт зөөврийн компьютер хүлээлгэн өгч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, 163.9 сая төгрөгийн үнэ бүхий сүүлийн үеийн зөөврийн компьютер хүлээлгэн өгсөн. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн албаны барилгыг улсын төсвийн 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, ашиглалтад оруулсан бөгөөд Цагдаагийн албан хаагчид тохитой орчинд ажиллах нөхцөл бүрдлээ.	100%
5	18	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг	16.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	Төрийн өмчийн барилга байгууламжийн судалгааг гарган дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг Улсын онцгой комисст хүргүүлэн ажилласан.	100%

		нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29			
6	19	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	21.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	"Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг 8 бүлэг, 35 зорилтын хүрээнд 182 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын цахим мэдээллийн сан new.unelgee.gov.mn-д тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн. 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцүүлж, 2023 оны 102 дугаар тогтоолоор "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн. 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 8 бүлэг 207 арга хэмжээг зохион байгуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 83 дугаар тогтоолоор батлуулсан.	100%
	20		7.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ.	Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дугаар захирамжаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн орон тоог баталсан бөгөөд тус хэлтэс нь 14 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд: Хэлтсийн дарга 1, аймгийн ерөнхий архитектор 1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэжилтэн 1, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн 1, Орон нутгийн хөгжлийн сан, төсөл, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн 1, Үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн 1, Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн 1, Байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн 1, Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн 1, Эрчим хүчний улсын хяналтын байцаагч 1, Авто замын хяналтын улсын байцаагч 1, Авто тээврийн хяналтын улсын байцаагч 1, Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч 1, Хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогч 1.	100%
7	21	Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06	43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Хоршоо хөгжүүлэх сангаас 1 дундын хоршоо, 4 анхан шатны хоршоонд 158,6 сая төгрөгийн зээлийг олгож, хоршоологчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, чадавхжуулах сургалтад хамруулж байна. Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 20 жилийн ойн арга хэмжээнд 120 гаруй зочид төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулсан. "Алтан намрын шим" хоршооны худалдаа үйлчилгээний борлуулалтын цэг байгуулахаар гэрэлтүүлэг, авто зогсоол, барилгын ажлыг эхлүүлж, 50 хувьтай хийж, гүний худаг, авто зогсоол байгуулахад нь 229,8 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	70%

				“АДРА Монгол” Олон Улсын байгууллагатай хамтран органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тэлж, хамтын баталгаажуулалтын тогтолцоо, органик хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн түншлэлийг бэхжүүлэх, орон нутгийн органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын үр ашигтай сүлжээг талуудын оролцоотойгоор бий болгох, органик үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн амьжиргааг сайжруулах зорилгоор “Органик хөдөө аж ахуйн түншлэл-II” төслийг 13 сум, 1 тосгоны 30 хоршоологчдыг хамруулан 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.	
8	22	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2021-07-07 Дугаар 2021.07.07	9.18. Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.	Үнэт цаасыг нийтэд санал болгож гаргаагүй.	100%
9	23	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Төрийн аудитын байгууллагаас 2022 онд хийсэн хяналт шалгалтаар “Үнэлгээний хороо”-нд томилогдсон гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулж, архивлах тухай дүгнэлтийг хэрэгжүүлж 2023 онд 83 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд давхардсан тоогоор оролцсон 419 албан хаагч, иргэдийн төлөөллийг тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулсан.	100%
	24		8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	"Силикат" ХК, "Адексмайн" ХХК, "Флинкмонголиа" ХХК, "Чамин-Алт" ХХК, "Хана-Интернэшнл" ХХК, "Тод-Ундарга" ХХК-уудтай байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулсан.	100%
10	25	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	5.2. Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно.	Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/42 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмааг ажлаас чөлөөлснөөр Засаг даргын орлогчийн албан тушаалыг нэг хүн эрхэлдэг болсон.	100%
	26	Дугаар 2022.04.29	10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийлэг жишгийг үйл ажиллагааны чиглэл,	70%

			харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	ашигт ажиллагааны түвшнийг харгалзан тогтоон ажиллаж байна.	
	27		13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1. Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 21,567.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 95 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан. Үүнээс 90 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны худалдан авах ажиллагааг тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтийг цахим системд ил тод байршуулан зохион байгуулсан. 14.2 тэрбум төгрөгийн 81 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгож, шалгараагүй шалтгааныг оролцогчдод бичгээр мэдэгдэж олон нийтэд цахим системээр мэдээлэн ажилласан. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”- (www.tender.gov.mn)-ийн гэрээ удирдах хэсэгт 81 гэрээний мэдээллийг үнэн зөв оруулсан. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.2-д зааснаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнасан болно.	100%
11	28	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28	5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3. Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр	Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/372 дугаар захирамжаар сумдын баяр наадмыг тэмдэглэх хугацааг тогтоосон. Алтанбулаг сум - 06 дугаар сарын 28, 29; Баруунбүрэн сум - 07 дугаар сарын 07, 08; Баянгол сум - 07 дугаар сарын 03, 04; Ерөө сум - 07 дугаар сарын 06, 07; Жавхлант сум - 07 дугаар сарын 06, 07; Зүүнбүрэн сум - 07 дугаар сарын 07; Мандал сум - 07 дугаар сарын 08, 09; Орхон сум - 07 дугаар сарын 05, 06; Орхонтуул сум - 07 дугаар сарын 10, 11;	100%

			наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.)	Сайхан сум - 07 дугаар сарын 07, 08; Сант сум - 07 дугаар сарын 07, 08; Сүхбаатар сум - 06 дугаар сарын 28-30; Түшиг сум - 07 дугаар сарын 05; Хушаат сум - 07 дугаар сарын 06, 07; Хүдэр сум - 07 дугаар сарын 07, 08; Цагааннуур сум - 07 дугаар сарын 06, 07; Шаамар сум - 07 дугаар сарын 02.	
12	29	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	“Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмших худалдаа үйлчилгээний газрын ангилал, түүнд тавих шаардлага”, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох” төсөлд санал хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 440 аж ахуй нэгж байгаа нь байх ёстой нормативаас хэтрээгүй байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгохдоо төрийн болон төрийн бус байгууллагын ажлын байр, хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар, оюутан сурагчдын хичээлийн болон дотуур байр, орон сууцны байр, орц, хонгил, гудамж талбай, цэцэрлэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, нийтийг хамарсан арга хэмжээ явагдаж буй газар, гал тэрэгний буудлын орчин тойронд /татваргүй барааны дэлгүүрээс бусад 50 м-ээс бага зайд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон газар олгохгүй, цаашид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог одоогийн тоо хэмжээнээс нэмэгдүүлэхгүй байх бодлого барин ажиллаж байна.	100%
	30		23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоон мөрдөж ажиллаж байна.	100%
УИХ-ЫН ТОГТООЛ					
13	31	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14	4.7.1.б. бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох;	Аймгийн хөгжлийн тулгуур салбарыг хөдөө аж ахуй, уул уурхайн салбар гэж тодорхойлж, “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Сэлэнгэ аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион	100%

		Дугаар 2001№57		байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгон ажиллаж байна. Аймгийн нийт өрхийн 50 орчим хувь нь хөдөө аж ахуйн чиглэлээр өрхийн үйлдвэрлэл эрхэлж, улсын хэрэгцээт үр тарианы 60 орчим хувь, төмсний 28 хувь, хүнсний ногооны 30 хувийг дангаараа бэлтгэж байна. Сумдыг 5 бүсэд хуваан, бүс бүрийн онцлогт тулгуурлан эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээг хөгжүүлэхээр төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.	
14	32		3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;	Стратегийн команд штабын сургууль 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус сургалт нь газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үеийн үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, Нэгдсэн шуурхай штаб, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг жигдрүүлэх, улсын гамшигтай тэмцэх болон төрийн цэргийн байгууллагын чиглэлийн төлөвлөгөөг тодотгох, нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, гамшиг хохирол багатай даван туулах чадавхыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж, аймгийн Онцгой комиссын гишүүд, Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн 50 гаруй бүрэлдэхүүн хамрагдлаа.	100%
	33	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшиг аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	Монгол Улсын 2020 оны 190 дүгээр тогтоолын хүрээнд 17 суманд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж ажилласан. Дээрх ажлын хэсэг нь 320 гаруй төрийн албан хаагчдад гамшиг эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг өгч ажилласан.	100%
	34		8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн	Гамшиг эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2022, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тусгаж тус бүр 50 сая төгрөгийг тусган, зарцуулан ажилласан.	100%

			улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.		
	35		1.5. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;	Аймгийн төв Сүхбаатар сум дахь ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих 6, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, газрыг шинэчлэн зохион байгуулах 1 газрын байршил хил заагийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 87 дугаар тогтоолоор батлуулж, Сүхбаатар сумын 7 дугаар баг 3, 4 дүгээр 8 айлын ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих төслийг “Колорс Теч” ХХК гүйцэтгэж байна. “Ашиглалтын шаардлага хангахгүй” дүгнэлттэй Мандал сумын 2-р сургуулийн 640 хүүхдийн барилгын зураг төслийг боловсруулж, 2024 онд 3,4 тэрбум төгрөг тусгагдсан. Газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн судалгааг гарган ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон сургууль, орон сууцны барилгуудад дүгнэлт гаргуулж, орон сууцны барилгуудыг дахин төлөвлөлтийн төсөлд хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан.	70%
15	36	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;	2022-2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр “Нөхөн сэргээх, хүүхэд хөгжил, сургалтын төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл эхэлсэн бөгөөд 2023 онд 2,600.5 сая төгрөгийн төсөв батлагдсан. Тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг хөгжлийг хангах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдөөд байна.	70%
16	37	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52	3.1. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн	“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Сэлэнгэ аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан боловсруулж, 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 102 дугаар тогтоолоор батлуулж хэлэлцүүлэн “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 8 бүлэг 207 арга хэмжээг зохион байгуулахаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 83 дугаар тогтоолоор батлуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 55,0 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,6 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	70%

			төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;	оруулалтаар 10,6 тэрбум төгрөг, хандиваар 2,7 тэрбум төгрөгийн нийт 194 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс гүйцэтгэл 60,2 хувьтай байна. Сумдад 1 тэрбум 37 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг шилжүүлсэн байна.	
17	38	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн Сэлэнгэ аймагт хамааралтай зорилт, арга хэмжээг хэрэгжилтийг сар бүр тайлагнаж, 9,1 тэрбум төгрөгийн 2 арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулсан.	70%
	39		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга, бат, хариуцлага, үр ашгийг сайжруулж ажиллах чиглэлийг сумын төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 600.0 сая төгрөгийн зураг төсөв хийлгэхээр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 82 дугаар тогтоолоор батлуулсан ба 335.0 сая төгрөгийн зураг төсвийг хийлгэх санхүүжилтийн эрхийг сумын Засаг дарга нарт шилжүүлж, 2023 оны байдлаар 80.0 сая төгрөгийн зураг төслийн санхүүжилтийг олгоод байна.	100%
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
18	40	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах,	3.1. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний	1. "Сүрьеэгүй Сэлэнгэ-2" арга хэмжээг 2023-2026 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 120 дугаар тогтоолоор 4 зорилт 20 арга хэмжээг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Хүн амын дунд бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол буурахгүй байгаа тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн зөвлөлийн болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн "Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, мэдлэг, хандлага өөрчлөх" сургалтын	100%

		урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	статистик ирүүлэх)	удирдамжийг батлуулсан. 3. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар баталсан "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх 2022-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан дөрөвдүгээр зорилт буюу "Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолыг вирусийн халдвараас сэргийлэх, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх, иргэн төвтэй эрүүл мэндийн цогц, чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах" хүрээнд нийт 11 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /2018 онд сүрьеэ-13,6, БЗДХ-49,3; 2019 онд сүрьеэ-14,7, БЗДХ-36.8; 2020 онд сүрьеэ-10,5 БЗДХ-49 промилл байна./	
19	41	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.1. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Аймгийн Засаг даргын 2023 оны 01/434 тоот "БЗДХ-ын өнөөгийн байдал урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, мэдлэг, хандлага өөрчлөх" сургалтын удирдамжийн дагуу цахим болон танхимаар аймаг, сум, тосгоны нийт 60 гаруй төр, хувийн хэвшил, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан албан хаагч, иргэдэд мэдээллийг хүргэсэн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар баталсан "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" 2022-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4 зорилт "Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолыг вирусийн халдвараас сэргийлэх, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх, "иргэн төв"-тэй эрүүл мэндийн цогц, чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах" хүрээнд БЗДХ, ХДХВ/ДОХ-ыг тусламж үйлчилгээг сайжруулах, эрт илрүүлэг, эмчилгээ, хяналтыг чанаржуулах, нөлөөлөл сургалтын ажил өрнүүлэх, халдвартай иргэдэд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүртээмжтэй, тогтвортой хүргэх, эмчилгээ, оношилгооны шинэ арга, технологи нэвтрүүлэх, дэмжлэгт хяналт хийх, "Дэлхийн ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг олон арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажилласан. 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, 03 дугаар сарын 23-ны өдрийн ИТХ-ийн хуралд тус тус БЗДХ-ын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал сэдвээр сонсгол тавьж ажилласан. Тус сонсголын дагуу аймгийн Засаг даргын удирдамжаар төр хувийн хэвшлийн байгууллагын алба хаагч, ажилтан нарт "БЗДХ-ын өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, мэдлэг хандлага өөрчлөх" сэдэвт сургалтыг аймгийн төвийн 18 байгууллагын 661 иргэн, 14 сум, тосгоны 681 иргэн нийт 1342 иргэнд хүргэсэн байна	100%
	42		2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг	2023 онд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд арга хэмжээний	100%

			эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	төлөвлөгөөний зардалдаа тусган нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагч болон үйлчлүүлэгч нарт ээлтэй орчин бүрдүүлэх, аюулгүй тарилга, нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл ашиглах, түгээмэл үйлдлийн стандарт мөрдөх гэх зэрэгт шат дараалсан хяналт тавин, мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж ажилласан. Эрүүл мэндийн газар бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хэрэгжилтийг хангах зорилгоор арга хэмжээний төлөвлөгөөний зардал буюу бараа үйлчилгээний бусад зардлаас 1,5 сая төгрөгийг сургалт сурталчилгаанд зарцуулан ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт нийгмийн эрүүл мэндийн сургалтын зардал төсөвлөгддөг ба үүнд ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны зардлыг тусгасан байдаг.	
20	43	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 3.240 мянган төгрөгийн төсвийг батлан, “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд 13.2 сая төгрөгийг зарцуулан, Монгол Улсад ГХУСА33-ийн Ажлын алба, “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-тэй хамтран аймгийн хэмжээний хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 255 гишүүн хамруулсан. Тайлант онд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд хамгаалал”, “Нуугдмал”, “Анхаар хүүхэд”, “Хүүхэд таныг хамгаалъя”, “Бүртгэл”, “Хамтдаа хамгаалъя”, Үе тэнгийн дээрэлхэлт гэж юу вэ?, түүнийг хэрхэн зогсоох, аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ?”, “Цахим орчинд хэрхэн аюулгүй байдлаа хангах вэ?”, бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зэрэг арга хэмжээнүүдийг сумдын сургууль, цэцэрлэгийн 17 эмч, цагдаагийн алба хаагч, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж 30 гаруй багш, 300 гаруй эцэг, эх, асран хамгаалагч, 2,0 мянга гаруй сурагч, мэргэжил, сургалт үйлдвэрийн төвийн 54 оюутныг хамруулсан.	100%
21	44	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26	3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “ЕБС-д кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн батлах А/465 тоот тушаал, чиглэлийн дагуу ЕБС-ийн нөхөн хангалтын зардлаас 26 сургууль интернэтийн хүчин чадлаа нэмэгдүүлж, 87 багш, 46 сурагчид шинээр зөөврийн компьютер, 436	70%

		№01 ИЦББХ	хангуулах	таблет худалдан авч анги танхимын орчин бүрдүүлж, тусгайлан 19 цахим анги шинээр тохижуулж “Эдүтэн” цахим систем хэрэгжүүлэхэд нийт 749,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 3-4 дүгээр ангийн 154 бүлгийн 4338 сурагчид тус хөтөлбөрөөр 7 хоногт 1 цаг, 5-6 ангийн 4167 сурагч Pearson цахим платформ дээр ажиллах системийн эрх үүсгэн, 7 хоногт 3 цагийн хичээлийг явуулж байна. Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг зөөврийн компьютер хангах ажлыг зохион байгуулж Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц хөрөнгөнөөс 50 хувь, Боловсрол, шинжлэх ухааны газрын нөхөн хангалтын зардлаас 50 хувийг шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангаад байна.	
22	45	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт мал эмнэлэг хорио цээрийн тусгаарлагдсан бүсэд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж үхэр бордох аж ахуйг байгуулан зах зээлд гарал үүсэл тодорхой, эрүүл чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгоор “Улаанбаатар гурил” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд мал эмнэлгийн лабораторийн барилгын ажил 90 хувьтай хийгдэж, мах махан бүтээгдэхүүн экспортолох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	100%
	46		1.5. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны судалгаа хөгжлийн төвтэй хамтран Баруунбүрэн, Орхон, Сант, Сайхан, Хушаат сумын 15 малчдын 82 малын махнаас дээж авч лабораторийн шинжилгээнд өгч хамтран ажилласан. Аймгийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний экспортод гаргаж буй аж ахуйн нэгж, иргэд байхгүй болно.	100%
23	47	Ноос ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-04-06 Дугаар 2021 №02 ҮББХ	4. 4/Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.	2023 онд бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн 41.5 сая төгрөг, оёмол бүтээгдэхүүн 14.0 сая төгрөг, мод, модон бүтээгдэхүүн 63.0 сая төгрөг, хүнсний бүтээгдэхүүн 4.2 тэрбум төгрөг, эм, био бэлдмэл 718.2 сая төгрөг, мал, эмнэлэг, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн 244.9 сая төгрөг, сав, баглаа боодлын бүтээгдэхүүн 66.2 сая төгрөг, зам, барилгын бүтээгдэхүүн 48.5 сая төгрөг, өнгөт болон хар төмөрлөг бүтээгдэхүүн 720.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмж, сэлбэг эд анги 72.9 сая төгрөг, жагсаалтад багтсанаас бусад 46.0 сая төгрөг буюу нийт	100%

				6.2 тэрбум төгрөгийн төрийн худалдан авалтыг дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлж, орон нутгийн бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжин ажилласан.	
24	48	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	1.2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	“Тэгш хамруулан сургах боловсрол” төслийн “Сургуулийн үдийн хоол” бүрэлдэхүүн төсөлд Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулиуд хамрагдан, гал тогооны үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмжийн талаар мэдээллийн сан үүсгэх, хэрэгцээ шаардлагыг бодитоор тодорхойлох, орчин нөхцөлд үнэлгээ хийж, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсгийг байгуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний улсын байцаагч, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний чанарын улсын байцаагч нар оролцон, гүйцэтгэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолонд 12 нэр төрлийн 77ш тоног төхөөрөмж, дотуур байрны гал тогоонд 8 төрлийн 26 ш тоног төхөөрөмж, цэцэрлэгт 12 нэр төрлийн 85 ш тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад 8 нэр төрлийн 10 ш тоног төхөөрөмж, нийт 198 ш 537,1 сая төгрөгийн өртөг бүхий гал тогооны үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж шаардлагатай байгаа бөгөөд холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлж, хүүхдийг эрүүл, аюулгүй, шим тэжээлт хоол хүнсээр хангах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%
	49		1.3. нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан орон тоог бий болгож, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх;	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний 28 тоот "Зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад ажиллах хоол, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан арга зүйч, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт батлагдсан ба Боловсрол, шинжлэх ухааны газарт 2021 оны 12 дугаар сарын 09-өөс хойш ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагууд болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна.	100%
	50		1./ Энэ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт нэмж шаардагдаж байгаа зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх;	Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй. /Цаашид хяналтаас хасуулах саналтай./	Х.Б
	51		1.8. багш, ажилчид, эцэг, эх, асран	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж,	100%

		хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх талаар арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх;	аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хоол хүнсний чанар, хүртээмжийг сайжруулах, сургалтын байгууллага дээрх хоол хүнсний үйлчилгээгээр дамжуулан нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэх боломж, үр ашиг, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд талуудын хамтын ажиллагаа, оролцоог хангах зорилгоор “Хүүхдийн хоол” сэдэвт хэлэлцүүлгийг орон нутгийн түвшинд танхим, цахим хосолсон хэлбэрээр аймгийн, Хүнс,хөдөө аж ахуйн газар Эрүүл мэндийн газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлага болгон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдыг хамруулан 280 гаруй төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газар Сумдын Эрүүл мэндийн төвтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үдийн хоол, эрүүл хооллолт, шимт бодисуудын ач холбогдол, өглөөний цайны ач тусын талаар сургалтыг зохион байгуулж, дэлхийн хүнсний өдрийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хоол шим тэжээлийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний ач холбогдлыг таниулах, хүүхдийн хоолны тогоочийн ажил мэргэжлийн онцлог, хэрэгцээ шаардлагыг олон нийтэд таниулах зорилгоор аймгийн хэмжээнд "Шим тэжээлийн боловсрол" нөлөөллийн аяныг нэг сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулж, мэдээллийг түгээсэн.	
52	1.9. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтын байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн улсын байцаагч, ХҮнс, хөдөө, аж ахуйн газрын хүнсний чанар, стандартын улсын байцаагч нар аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хоол, хүнсний болон орчны аюулгүй байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үүний үндсэн дээр хоол, хүнсний чанар сайжруулах чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж үүрэг, чиглэл хүргүүлэн ажилласан. 2023-2024 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежуудын бэлтгэл ажлыг хангуулж, салбарын хууль, журам, тушаалын хэрэгжилтийг хангуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр Эрүүл мэндийн газрын улсын байцаагчийн зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлсэн.	100%	
53	1.10. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний	Аймгийн хэмжээнд 35 ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн 10651 сурагч үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэгч нартай худалдан авах гэрээ байгуулан худалдан авсан.	100%	

			худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;		
	54		1.11. 2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын орчин нөхцөлийг сайжруулах, сурагч, багш, ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Япон улсын "Өвчний үндэс-Хүний эрүүл мэнд" хөтөлбөрийн 600.0 сая төгрөгийн тусламжаар Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд засварын ажил хийгдэж дууссан.	100%
25	55	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ	1.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах;	Биеийн тамир спортын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган биеийн тамирын багш нарын улсын зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг орон нутагтаа хэрэгжүүлэх биеийн тамир спортыг хөгжүүлэх хэтийн бодлого зорилтыг ханган ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар Биеийн тамир спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан батлуулж, шигшээ баг байгуулах, биеийн тамирын гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн үйл ажиллагааг дэмжин хүүхдийн элсэлтийг нэмэгдүүлэн хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, цахим спортын бүртгэл, судалгаатай болж, бүх сумдад орон тооны болон орон тооны бус арга зүйчтэй болж хамтран ажиллаж төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн биеийн тамирын арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулснаар иргэдийн спортоор хичээллэх боломж нэмэгдэж, бие бялдрын чадавх өсөн нэмэгдсэн. 2023 онд аймаг орон нутгийн төсвөөс 113,8 сая төгрөг, улсын төсвөөс 124,1 сая төгрөг буюу нийт 238,1 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн хэмжээний аварга шалгаруулах биеийн тамирын 95, Улсын аварга шалгаруулах 35 удаагийн тэмцээнд 21 аймаг 9 дүүргийн 8063 тамирчин оролцуулан зохион байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эерэг хандлага- эрүүл Монгол иргэн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цаг гаргая” аяныг 3 сарын хугацаанд спорт заал болон усан спорт сургалтын төв, Баянгол, Алтанбулаг, Дулаанхан тосгон, Цагааннуур, Ерөө, Мандал, Сайхан, Баруунбүрэн сумдын спорт зааланд өглөө бүр иргэдэд 2 цаг үнэ төлбөргүйгээр үйлчлэх чиглэл өгч ажилласнаар арга хэмжээнд нийт 17 сумын 11969 иргэнийг хамруулан аяны хүрээнд “Сэлэнгэ лиг-2023” оюутан, залуучууд, 40-өөс дээш насны ахмадуудын дунд иргэдийн	100%

			спортын наадам, аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын нөхөрсөг уулзалт тэмцээн зэрэг томоохон арга хэмжээг явуулан түүнд 1960 хүнийг оролцуулан нийт 19616 хүнийг татан оролцуулан ажиллалаа.	
56		1.5. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын дагуу Биеийн тамир спортын Улсын хорооноос ирүүлсэн 2021-2024 онд улсын хэмжээнд 273 арга зүйч ажиллуулах чиглэлийн дагуу 10 сум 6 тосгодоос 21 хүний материалын бүртгэл мэдээллийг хүргүүлсэн. Алтанбулаг суманд спорт цогцолбор ашиглалтад орж үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлээр арга зүйч болон бусад 4 орон тоог төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуульд 435 клуб, секц, дугуйлан хичээллэж 9463 хүүхэд хамрагдаж 451 багш, 23 иргэн өөрийн авьяас чадвар, нөөц боломжид тулгуурлан гэрээгээр ажиллаж сургуулийн орчинд хүүхдийн биеийн тамир спортын авьяас чадварыг нээн, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.	100%
57		1.6. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Биеийн тамирын багш арга зүйч, дасгалжуулагч нарын ур чадварыг дээшлүүлэх тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн ажлын эрч хүчийг сайжруулах ажлын хүрээнд багш дасгалжуулагч нарын өрөө тасалгаанд шаардлагатай тавилга тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа. Засгийн газрын тохируулагч агентлагийн Биеийн тамир, спортын хороо, Төрийн албаны зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан цахим болон танхимын 14 сургалтад давхардсан тоогоор 304 албан хаагчийг хамруулсан. Биеийн тамир спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 153 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс биеийн тамир спортын талаар баримтлах бодлого"-ын хүрээнд аймгийн хэмжээнд 2020-2028 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх "Спортлог-Сэлэнгэчүүд" хөтөлбөрийн эхний үе шатыг 80 хувьтай хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100%
58		1.12. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд	Сумдын орон тооны биеийн тамирын арга зүйч нартай хамтран Сүхбаатар суманд партизаны талбай, гэрэлт цогцолбор, төв цэнгэлдэх, Мандал суманд ноён уулын цогцолбор, Сайхан суманд гавшгай толгой, Алтанбулаг суманд Сүхбаатарын хөшөө, Ерөө суманд Трактортой толгой хүртэл өглөө бүр 2000-2500 гаруй иргэд биеэ тогтмол чийрэгжүүлэн, алхалт хийж байна. Спортын 8 цогцолбор тус бүрт 2022-2023 онд 0,5 сая төгрөгийн багц /сагсан бөмбөг, волейбол, шүгэл, секундомер, волейболын тор, сагсны тор, 4 сая төгрөгийн спортын хэрэглэл материалыг нийлүүлж, барилга байгууламжийн урсгал засварт 442,0 сая төгрөг, спортын хэрэглэл материалд 101,0 сая нийт	100%

			биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	543,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Биеийн тамир спортын улсын хорооноос биеийн тамир спортыг бэхжүүлэх, материаллаг баазыг сайжруулах чиглэлээр техник хэрэгсэл, тавилга, спортын хэрэгсэл гэсэн 3 чиглэлээр 60,0 сая төгрөгийн ширээ сандал, 5 ширхэг компьютер, жүдо бөхийн татами авч орчин нөхцөлөө сайжруулсан. Хүдэр сумын спортын цогцолборын барилга угсралтын ажлыг 1,800,0 сая төгрөг, Баянгол спорт цогцолборын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн "Бороогоульд" ХХК 243,0 сая, "Mindtech" ХХК 9,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр "Сайн мод бид бүтээнэ" ХХК их завсрыг хийж гүйцэтгэсэн.	
26	59	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	1.5. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2023 онд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг салхи, ус борооны элэгдэл, эвдрэлээс хамгаалах, чийг хуримтлуулах, хөрсний бүтцийг тогтвортой сайжруулах зорилгоор улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 115.1 мян.га талбайг хашаажуулж, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Орхон, Сайхан, Хүдэр, Хушаат сумдын 8 аж ахуйн нэгж 645 га талбайд агро-ойжуулалт хийж, 17,3 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалж 24,4 мянган тн хураан авсан байна.	100%
27	60	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ	1.1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх;	2020 оны Улсын төсвийн XV.2.1.3 хуулийн дугаартай 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон голын төмөр бетон гүүрний угсралтын ажлыг "Эрдэнэт суварга" ХХК гүйцэтгэн 1 ээлжийн угсралтын ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн. 2022 онд улсын төсвийн 15.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг хилийн боомтын чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг "Монкон" ХХК гүйцэтгэн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн.	100%
	61		1.2. төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах;	2022 оны Улсын төсвийн 15.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг хилийн боомтын чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг "Монкон" ХХК гүйцэтгэж 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%
	62		1.3. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан	Хөрөнгө оруулалтын ажлуудын төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглаагүй, шинээр 25 ажлын зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай	Х.Б

		гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох;	олгон мэргэжлийн байгууллагаар хянуулан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвөөр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэж байна. /Цаашид хяналтаас хасуулах саналтай./	
63		1.4. захиалагчаас тогтоосон нөхцөл, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу 2022 оны 4 дүгээр сард багтаан тус тус сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэн гүйцэтгэлд хяналт тавих;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 55,0 тэрбум төгрөгийн 37 төсөл, арга хэмжээ, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,3 тэрбум төгрөгийн 81 төсөл, арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,4 тэрбум төгрөгийн 60 төсөл, арга хэмжээ, хандивын эх үүсвэрээр 2,7 тэрбум төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ, нийт 194 төсөл, арга хэмжээг захиалагчийн баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэлийг зохион байгуулж, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-тай хамтран тогтмол хяналт тавин ажилласан. /Цаашид хяналтаас хасуулах саналтай./	Х.Б
64		1.5. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох;	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй бүхий л барилга байгууламжуудад “Барилгын тухай хууль” түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн “Барилга захиалагчийн дүрэм”-ийг баримталж захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн заавар зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2023 онд улс болон аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 139 ажил эхлэх зөвшөөрөл олгож, 125 ажлыг хүлээн авсан, Барилга захиалагч” ОНӨААТҮГ-аас гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаж 101 ажлыг хүлээн авч ажилласан байна.	100%
65		1.6. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд	Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун	100%

			аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.	цэврийн байгууламжаар солих төслийн хүрээнд 10 сумын сургуулийн хичээлийн 12 байр, 5 дотуур байр, 4 цэцэрлэг нийт 21 объект сонгогдсон. I, II ээлжид Баруунбүрэн, Цагааннуур 2 сумын сургууль, цэцэрлэгийн дотуур байр 6 объектод ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангахуйцаар сайжруулах ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авсан. III ээлжид Алтанбулаг сумын сургуулийн хичээлийн 2-р байр, цэцэрлэг, Баянгол сумын сургуулийн хичээлийн байр, Зүүнбүрэн сумын сургуулийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэг, Хушаат сумын сургуулийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэг зэрэг 4 сумын 9 объектод зураг төсөв, магадлал хийгдэж, барилга угсралтын тендер зарлагдан үйл ажиллагаа эхлээд байна. IV ээлжид Түшиг сумын хичээлийн байр, дотуур байр, Ерөө сумын Бугант тосгоны сургуулийн хичээлийн байр, Мандал сумын 1-р сургуулийн хичээлийн байр, Мандал сумын Тарни багийн сургуулийн хичээлийн байр, Орхонтуул сумын Рашаант тосгоны сургуулийн хичээлийн байр зэрэг 4 сумын 6 объектын зураг, төсвийн ажил үргэлжилж байна. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийгдээгүй.	
28	66	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	1.4. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	Мал эмнэлгийн нийт 786 цахим гэрчилгээгээр 6.8 мянган толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн. Үүнээс өөр аймаг, сумруу мал эмнэлгийн 449 цахим гэрчилгээгээр 3.9 мянган толгой мал амьтан /отор-36, мал хэрэгцээлэх-3625 үржил-284/ явсан, өөр аймаг сумаас мал эмнэлгийн 197 цахим гэрчилгээгээр 1.5 мянган толгой мал, амьтан /отор-47, мал амьтан хэрэгцээлэх-1208 үржил-263/ ирсэн, аймаг дотроо мал эмнэлгийн цахим 140 гэрчилгээгээр нийт 1.3 мянган толгой мал, амьтан /отор-7, үржил-159, мал, амьтан хэрэгцээлэх-1174/ шилжилт хөдөлгөөн хийхэд хяналт тавьж баталгаажуулан ажилласан.	100%
	67		1.5. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан	2023 онд Баруунбүрэн, Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Сүхбаатар сумдад оношлогдсон мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах үед дээрх сумдын бүх шатны албан тушаалтнууд зөрчил гаргаагүй.	100%

			үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;		
	68		1.6. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2023 онд малын тоо толгойн албан татварын орлого 3 тэрбум 52.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1 тэрбум 160.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт орлогын 38.0 хувийг эзэлж байна.	100%
	69		1.7. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	100%
29	70	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6. Улсын хэмжээнд сум бүрийг "Ахмадын өргөө"-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Улсын төсвийн 2,2 тэрбум төгрөгийн төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал суманд ахмадын байр барих ажлыг "Мэргэндэнэн" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан төсвийн жил 130,2 сая төгрөг нийт 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажлын гүйцэтгэл 55,4 хувьтай байна. Ерөө сумын Бугант тосгоны "Ахмадын өргөөний байр"-ыг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 100 сая төгрөгөөр засварлаж ашиглалтад оруулсан. Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн дагуу аймгийн 2023 оны төсөвт 107,7 сая төгрөгийг ахмад настны хөгжил, хамгаалал, нийгэм дэх идэвх оролцоог нэмэгдүүлэх, ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг сайжруулахад чиглэлээр батлуулж сар бүр хуваарийн дагуу үйл ажиллагааны тайланд үндэслэн санхүүжилтийг олгосон.	70%
30	71	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ	1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй	Хоршоог хөгжүүлэх сангаас Мандал сумын "Тансаг цагаан идээ", Сант сумын "Эсэргэнэ", Цагааннуур сумын "Хуурч сүрэг" хоршоонд мах, сүүний боловсруулах цехийн тоног төхөөрөмж 15 сая төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангаас Жавхланта сумын Э.Цэрэнчимэд, Түшиг сумын У.Одончимэг, Д.Цогзолмаа нарт сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех	100%

			аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	байгуулахад 24,8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлсэн. Жижиг, дунд үйлдвэрийн газартай гурван талт гэрээг байгуулан 10 суманд 11 ширхэг арьс ширний анхан шатны боловсруулалт хийх сойзон махлагчтай тоног төхөөрөмж, сүүнээс цөцгий ялгах цахилгаан ажиллагаатай тоног төхөөрөмж 17 ширхгийг сумдад хуваарилан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар түрээсийн төлбөрийг төлөн, ашиглах талаар чиглэл хүргүүлэн ажилласан.	
31	72	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ	1.2. Импортлогч улсын хорио цээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд мал эмнэлгийн лабораторийн барилгын ажил 80 хувьтай хийгдэж, 56 нэр төрлийн 998,0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж, 94.5 сая төгрөгийн оношлуур, эм урвалж, 102 нэр төрлийн 133.9 сая төгрөгийн лабораторийн тавилга хэрэгслийг нийлүүлж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Оросын холбооны улсаас адуу 70, үхэр 81, хонь 44 толгой буюу нийт 195 толгой мал импортоор орж ирсэн бөгөөд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлж 9 нэр төрлийн өвчний шинжилгээг хийж, халдваргүй болохыг тогтоосон. Мөн 305 ААН-ийн өндөг 3024519 ш, гахайн мах 4066.7 тн, тахианы мах 655.7 тн, үхрийн мах 49.5 тн, загасны мах 22.3 тн, жигнэмэг, чихэр, бялуу 107.1 тн, боловсруулсан төмс 19.5 тн буюу нийт 4920.8 тн бүтээгдэхүүний 614 сорьц дээжид тус тус эмийн бодисын үлдэгдэл, уургийн задрал болон бусад ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу тус тус шинжилж баталгаажуулан, холбогдох газар луу шилжүүлсэн.	100%
32	73	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	Тужийн нарсны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаатай хамтран Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар сумдад хууль бусаар мод бэлтгэх, хулгайгаар ан агнах, зөвшөөрөлгүй ойгоос мод шилжүүлэн суулгах асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтын ажлыг 3 удаа зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн хэрэг, зөрчил илрээгүй. Тусгай хамгаалалттай газар нутгийн ойр хавьд газар олголт хийгдээгүй байна.	100%
33	74	Чиглэл өгөх тухай	1.1.4. асрамж, халамжийн төв, түр	Аймгийн хэмжээнд Мандал, Алтанбулаг, Сүхбаатар суманд түр	100%

	2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;	хамгаалах байр үйл ажиллагаа явуулж байна. Түр хамгаалах байрууд хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагад тусгагдсан хүний үндсэн болон тусгай хэрэгцээг бүрэн хангасан, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ онд Мандал сумын түр хамгаалах байрны сэтгэл зүйч болон эмнэлгийн үзлэгийн өрөөнд 12.700.000 /арван хоёр сая долоон зуун мянган/ төгрөгөөр засвар үйлчилгээ хийж, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар орон тооны сэтгэл зүйчийг ажиллуулж байна. 2023 онд гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан нийт 490 иргэнд зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: -Сэтгэл зүйн ганцаарчилсан-193 /насанд хүрэгч 15, хүүхэд 76/ -Бүлгийн-297 /хүүхэд/ -Хосын зөвлөгөө-4 /насанд хүрэгч/ -Цахимаар-21 /насанд хүрэгч 18, хүүхэд 41/ -Түр хамгаалах байранд үйлчилгээ авсан бэлгийн хүчирхийллийн хохирогч 1 хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 2 насанд хүрэгч, 3 хүүхдэд сэтгэл зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. -Цахим сэтгэл зүйн зөвлөгөө өгөх цахим хуудсаар дамжуулан 16 зөвлөмж, 12 постерыг байршуулсан. -Шүүгчийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 9 өрхийн 18 насанд хүрэгч, 15 хүүхдээс сэтгэл зүйн 14 багц тест авч, нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилласан.	
75		1.1.9. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;	“Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөртэй хамтран 16,3 сая төгрөгийн санхүүжилтээр насанд хүрээгүй хохирогч хүүхдийн “Мэдүүлэг авах өрөө”-г стандартын дагуу тохижуулсан. Тус өрөөгөөр Цагдаагийн газрын мөрдөн байцаагч насанд хүрээгүй сэжигтэн, хохирогч хүүхдүүдээс мэдүүлэг, тайлбар авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Цагдаагийн газраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн зориулалтын 3 өрөөг ашиглаж байна. Аймгийн хэмжээнд 2 эмэгтэй мөрдөгч ажиллаж байгаа бөгөөд насанд хүрээгүй хүн хохирсон бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг ижил хүйсийн мөрдөгчөөр шалгуулах бодлого баримтлан ажиллаж байна. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах, уулзалт хийх зориулалт бүхий 1 өрөөг “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар тохижуулж, 2023 оны 09 дүгээр сараас эхлэн ашиглаж байна	100%
76		1.1.12. “Хөдөлмөрийн тухай	Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан	100%

		хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.	байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд аймгийн Засаг даргын "Хүүхэд хамгаалалд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 03 тоот албан даалгавар батлагдаж төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт 16 төрлийн үүрэг, чиглэлийг хүргүүлэн уг албан даалгаврын 1.5 дугаар заалтад "Ажилтан хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх, авах боломжоор ханган, ажлын цагаар хүүхдийн дуудлагад хариу өгөх боломжоор хангах талаар дотоод журамд тусган хэрэгжүүлнэ", сум, тосгод өөрийн нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон хүүхэд хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлнэ гэж заасны дагуу төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллаж байна.	
77		1.2.1. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;	"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан "Зуун зууны хөтөч" төрийн бус байгууллагаас 1-3 нас, 4-5 насны ангиллаар хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг зохион байгуулж, шилдгүүдийг шалгаруулан шагнаж урамшуулсан. "Амигүрүми" буюу нэхмэл тоглоом хийх сургалтыг 15 ээж, 15 хүүхдэд зохион байгуулж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн нийт 330 гаруй хүүхдийг хамруулан "Мэргэжил сонголт"-ын арга хэмжээ, аймгийн Нийтийн номын сангийн санаачилгаар "Бяцхан санхүүч" сургалт, "Наран хүүхэд од" төрийн бус байгууллага, АНУ-ын төрийн департаментын Боловсрол Соёлын асуудал хариуцсан товчооны санхүүжилтээр англи хэлний "Аксесс" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 сурагчийг хамруулан Туж сургалтын төвд сургалт зохион байгуулсан. Хүдэр, Зүүнбүрэн, Ерөө сумын Соёлын төвийн шинээр баригдах барилгын төсвийг 2024 онд шийдвэрлүүлэн ажилласан. Соёл, урлагийн 26 байгууллага "Бүх нийтийн соёлын боловсрол" хөтөлбөрт хүүхдэд багачуудад зориулсан соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна. Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх "Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилгыг 3,1 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Бүрэн-Одод" ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байгаа бөгөөд 2024 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.	100%
78		1.2.2. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг	"Анбаунд Монгол" төрийн бус байгууллагатай хамтран "Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалтыг 1200 гаруй ерөнхий боловсролын сурагчид, мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад зохион байгууллаа. Гэмт хэрэг, зөрчилд насанд хүрээгүй хүн өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготойгоор ерөнхий	100%

			сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах;	боловсролын ахлах ангийн 350 гаруй сурагчдад “Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сургалтыг аймгийн хэмжээний 120 гаруй багш ажилчдад, “Хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан. “Найз байя” үндэсний аяныг 6 чиглэлийн хүрээнд зохион байгуулж, Цагдаагийн газраас энэ төрлийн хэрэгт насанд хүрээгүй хүүхэд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, орон нутгийн цахим зарын группт тавигдаж байгаа мэдээлэлд хяналт тавих зорилгоор “Цахим хяналт” тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний дүнд хандалт ихтэй 18 зарын группийн судалгааг гаргаж, дээрх группт хөтөч админ, модератор эрхтэйгээр цагдаагийн алба хаагчийг оролцуулж, энэ төрлийн мэдээллийг устгах, хуурамч хаягийн хандах эрхийг хязгаарлах зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, энэ төрлийн хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 320 гаруй эцэг эх, асран хамгаалагчдад мэдээллийг хүргэж ажилласан.	
	79		1.2.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах;	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын санхүүгийн тайланд жил бүр Төрийн аудитын газраас аудит хийж байна. 2016-2017 онд зөрчилгүй дүгнэгдэж, 2018 онд итгэл үзүүлсэн. 2019-2022 онуудад зөрчилгүй дүгнэлттэй ажиллалаа.	100%
	80		1.2.6. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх.	Хүүхдийн эрхийн улсын байцаагч нэг ажиллаж байгаа ба тайлант онд хүүхдийн эрх зөрчигдсөн 54 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Хүүхдийн эрхийн зөрчлийн 11 өргөдөлд хуулийн дагуу зөрчлийн хэрэг нээж 5,700,000 төгрөгийн торгууль оногдуулан, зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой 11 өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн. Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 8 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 2891 хүүхэд, 2084 иргэдийг хамруулсан.	100%
34	81	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	бв/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оbа1 1пШайуе Тог Е вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн	Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь "MACAM-2" төсөл манай аймагтай хамтарч иргэдийн төсөв ном гаргалаа. Тус номонд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, төсвийн тухай ерөнхий ойлголт, төр иргэн эгэх холбоотой ажиллах, иргэд төсвийн тухай ерөнхий ойлголт өгөх, улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнүүдийн талаар мэдээлэлтэй болж байгаа юм. Нийгмийн эгэх хариуцлагыг системтэй хэрэгжүүлснээрээ: -Төрийн бодлого үйлчилгээг сайжруулах	100%

		<p>оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох;</p>	<p>-Засаглах үйл ажиллагааг сайжруулах -Иргэд, иргэний нийгмийн бүлгүүдийг хүчирхэгжүүлэх -Төр болон иргэдийн хоорондын бүтээлч оролцоог нэмэгдүүлэх -Иргэний эрх, үүргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Швейцарын хөгжлийн агентлаг болон Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” буюу МАСАМ II төслийн хүрээнд аймгийн “Иргэдийн төсөв” эмхэтгэлийг бүтээв.</p>	
82		<p>бг/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 8.4.3-д заасны дагуу Сангийн яамнаас ирүүлсэн 2023 оны төсвийн төслийн удирдамжийн дагуу орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нараас төсвийн байгууллагуудын төсвийн төсөл, төсөөллийн саналыг хүлээн авч хянан нэгтгэн холбогдох тайлбар, тодруулга, судалгааны хамт вебэд суурилсан төсвийн төлөвлөлтийн фискал программд шивж нэгтгэн цахимаар, Сангийн яаманд хянуулан ажилласан. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг shilendans.gov.mn, selenge.gov.mn, статистикийн хэлтэс, ил тод байдлын мэдээллийн самбарт, сар бүрийн 8-ны дотор мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан. 2023 оны 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 72,7 сая төгрөг буюу 131,4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 25,1 сая төгрөг буюу 116.1 хувийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 47,0 сая төгрөг буюу 141,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн зарлага 101,5 сая төгрөг буюу 88,7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн зарлага 43,7 сая төгрөг буюу 100,7 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 57,8 сая төгрөг буюу 88,7 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн ажил олгогч эздийн холбоо”- ТББ, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ТББ-тай хамтарсан орон нутгийн төсвийн төлөвлөлт гүйцэтгэлд хөндлөнгөөс хяналт тавин хамтран ажилладаг. Төсвийн тухай хуулийн 63.1-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 75186 иргэнээс 534 төсөл арга, хэмжээний санал авч эрэмбэлж, аймгийн орон нутгийн хөгжлийн сан 10,4 тэрбум төгрөгөөр 60 төсөл, арга хэмжээ, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар 16,8 тэрбум төгрөгөөр 275 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар 9,1 тэрбум төгрөгөөр 53 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.</p>	100%
83		<p>ба/. аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг</p>	<p>Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс аймгуудын хөгжлийн давуу болон сул талыг тогтоож, өрсөлдөх</p>	100%

			<p>боловсруулан баталж, мөрдүүлэх, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянах;</p>	<p>чадварын боломж, чадавхыг үнэлэн гаргасан аймгуудын өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлтээр 2022 онд Сэлэнгэ аймаг 6 дугаарт эрэмбэлэгдсэн.</p> <p>Орон нутгийн хөгжлийн индексийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, мэдээллийг цахим системд бүрэн оруулах чиглэлийг сумдын Засаг дарга, статистик хариуцсан мэргэжилтэн, санхүү төрийн сангийн мэргэжилтэнд хүргүүлэн 17 сумын хөгжлийн индексийн мэдээллийг www.ldi.nda.gov.mn цахим системд оруулж, баталгаажуулсан.</p>	
Ерөнхийлөгчийн зарлиг					
35	84	<p>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46</p>	<p>3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.</p>	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/177 тоот захирамжаар "Үндэсний бичигтэн 2022-2024" хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллаж байна. Монгол хэлний бодлогын салбар зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу "Гудамж зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуй нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" MNS 5283:2022 стандартыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг агентлагийн дарга, сумдын Засаг дарга, байгууллагын дарга нар т хүргүүлсэн. Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" /MNS 6395:2022/, төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага /MNS 6978:2022/-ын талаарх мэдээллийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн цахим хуудаснаас авч, төрийн байгууллагуудад хүргүүлэн албан бичиг, тушаалыг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих, албан тасалгааны хаяг, нэрийн хуудсыг монгол бичгээр бичих, төрийн албан хаагчдад монгол бичгийн хичээлийг түвшинд ангилан заах ажлыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, ерөнхий боловсролын сургуулийн Монгол бичгийн багш нартай хамтран зохион байгуулж байна. Төрийн албан хэргийг кирилл, үндэсний бичгээр хослон явуулах бэлтгэл ажлыг хангах, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд аймгийн хэмжээний төр төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтнүүдэд "Цахимд үндэсний бичгээр бичих арга зүй" сургалтыг 5 дугаар сарын 9-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад 17 сум, 6 тосгоны Засаг даргын Тамгын газар, захирагчийн албаны архив, бичиг хэргийн ажилтнууд болон төр, төсвийн байгууллагуудын 180 гаруй албан хаагчдыг хамруулсан. Албан байгууллагын</p>	70%
36	85	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104</p>	<p>1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт</p>	<p>Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын орчимд түргэн хоол, түргэн үйлчилгээний цэгүүд үйл ажиллагаа явуулдаггүй. Ерөнхий боловсролын сургуулиас 150 метрийн радиуст байрлах хүнсний худалдаа үйлчилгээ үзүүлж буй 38 объектод урьдчилан сэргийлэх</p>	70%

			тавих	шалгалтыг зохион байгуулж, 146 зөрчлийг илрүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 96 заалттай 8 хугацаатай албан шаардлагыг өгч, 102 зөрчлийг арилгуулсан.	
37	86	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Аймгийн хэмжээнд 17 сум, 6 тосгоны 2410 иргэн, 287 аж ахуйн нэгж, байгууллага 7043 м2 цэцгийн мандал, 4012 м2 талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж, ойжуулалтын ажлыг 2624,9 га талбай, 9,3 сая модыг тарьж, ногоон байгууламжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад Улсын Тэргүүний нэрэмжит төгөл"-ийг Тужийн нарсанд 2 га газарт байгуулж, 5500 ширхэг мод тарьж, Дорноговь, Өмнөговь аймгуудад "Сэлэнгэ аймгийн нэрэмжит төгөл" байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгон ажиллаж байна.	100%
	87		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явц, үр дүн аймгийн зөвлөгөөн"-ийг аймгийн төв Сүхбаатар хотод 400 гаруй холбогдох төлөөллийг хамруулан зохион байгуулж, "Номгон Форестри" ХХК, Монгол-Солонгосын "Мониторинг Үндэсний төв", "Бугант Нандин" ХХК, "Тод Ундарга" ХХК-ууд барель ойг нөхөн сэргээх, бургасжуулах, ойжуулах, ойн зурвас байгуулах төслийг хэрэгжүүлж, эрдэс баялгийн салбарын "Болд Төмөр Ерөө гол" ХХК, "Дархан Төмөрлөг" ТӨХК, "Цемент шохой" ТӨХК-ууд Хүдэр, Ерөө, Сайхан, Хүдэр, Сант, Орхон, Орхонтуул сумдад нийгмийн хариуцлагын хүрээнд 2023-2030 онд 131,2 мянган га талбайд 328,6 сая ширхэг мод тарих гэрээ байгуулж, ойг нөхөн сэргээх, бургасжуулах, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг эхлүүлж, энэ онд 17 сум, 6 тосгоны 5219 иргэн, 545 аж ахуйн нэгж, байгууллага мод тарих ажилд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулсан.	100%

				“Ойн хүрэм” ХХК Ерөө суманд 130 га, Мандал суманд 50 га, “Бугант минж” ХХК Баруунбүрэн суманд 20 га талбайд ойжуулалт, мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллага 1117,4 га, гадаадын хөрөнгө оруулалтаар 5,5 га, уул уурхайн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 1250 га талбай буюу нийт 2624,9 га талбайд ойжуулалт хийж, төрийн болон төрийн бус байгууллагуудад мод тарьж ургуулахыг уриалж ажилласан.	
	88		1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Хөв цөөрөм байгуулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 300-560 сая төгрөгийг зарцуулж Орхон суманд 1 хөв цөөрөм байгуулсан.	100%
	89		1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн зөвлөмжийн дагуу манай аймгийн байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохирсон ургах боломжтой модны судалгааг гарган хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
	90		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах ажлын хүрээнд 17 сум, 6 тосгоны 2410 иргэн, 287 аж ахуйн нэгж, байгууллага 7043 м2 цэцгийн мандал, 4012 м ² талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж, ойжуулалтын ажлыг 2624,9 га талбай, 9,3 сая модыг тарьж, ногоон байгууламжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад Улсын Тэргүүний нэрэмжит төгөл”-ийг Тужийн нарсанд 2 га газарт байгуулж, 5500 ширхэг мод тарьж, Дорноговь, Өмнөговь аймгуудад “Сэлэнгэ аймгийн нэрэмжит төгөл” байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлсэд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалан ажилласан.	100%
38	91	Засгийн газарт	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын	Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшнийг дээшлүүлэх, идэвхтэй	100%

		чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	хөдөлгөөнөөр хичээллэх боломжийг бүрдүүлэхээр гаргасан аргачлалын дагуу 2023 онд Орхон, Сайхан сум болон Дулаанхан тосгонд өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулан нийт 4240 иргэнийг хамруулсан. Тус арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 800,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж одоогоор 5 арга хэмжээнд 4,0 сая төгрөгийн санхүүжилтийг, сумдад олгоод байна. Аймгийн хэмжээнд иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх боломжоор ханган үйлчилгээ үзүүлж буй биеийн тамир спортын клуб, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин 15 байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.	
39	92		2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдөр “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дүгээр зарлигийн дагуу аймгийн хэмжээний нийт төр, төсвийн байгууллагад Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залж, зарлигийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/493 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 200 ширхэг эш хөргийг хэвлүүлж, төрийн байгууллагуудад хүлээлгэн өгч ажилласан. 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр ерөнхий боловсролын 35 сургууль, 43 цэцэрлэг эш хөргийг хүндэтгэлтэйгээр байгууллагадаа залсан.	100%
	93	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдөр “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дүгээр зарлигийн хэрэгжилтийг хангах, айл өрхүүдэд уриалж ажиллах талаар үүрэг чиглэлийг сумдын Засаг дарга нар болон байгууллагуудын удирдлагуудад хүргүүлсэн. Монгол хүн бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай уриалга болон аймгийн нутгийн удирдлагын ордонд эш хөргийг хүндэтгэн залсан тухай мэдээллийг "Монцамэ" агентлаг, аймгийн албан ёсны цахим хуудас selenge.gov.mn, "Сэлэнгэ Аймаг ЗДТГ" цахим хуудсуудаар олон нийтэд түгээж, эш хөргийн батлагдсан хэмжээ, загварыг олон нийтэд танилцуулсан.	100%
	94		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ	Боловсролын байгууллага бүр хүндэтгэлийн булан байгуулан Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залж, хүүхэд багачуудад түүний түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, суу алдрыг судалж, эрхэмлэн дээдлэхийг уриалж, бага боловсрол буюу 1-5-р ангид Монгол ёс хүмүүжил хичээл долоо хоногт 2 цагаар, 6-12-р ангид иргэний ёс зүйн боловсрол хичээлийн заавал судлах 17 цагийн агуулгаар дамжуулан суралцагчдад төрт ёс, нийгмийн харилцаа, өв соёл, 21-р зууны иргэнд шаардагдах хувь хүний ур чадвар олгох арга хэмжээг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлж байна.	100%

		оруулахыг уриалсугай.			
ҮАБЗ-ийн зөвлөмж					
40	95	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, сууринуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Сүхбаатар суманд дахин төлөвлөлтөд оруулахаар 7 байршлыг тодорхойлсон. 2023 оны 09 дүгээр сард 7-р багийн 3, 4 дүгээр 8 айлын орон сууцыг буулгаж, талбай дээр нь 336 айлын 4 блок бүхий орон сууц барихаар суурийн ажил хийгдэж байна.	100%
	96		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний удирдамж, 2023 оны 2 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Стратегийн команд штабын сургууль” зохион байгуулах тухай тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 10/1071 дүгээр албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэлийн хүрээнд иргэд, олон нийтэд, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг мэдээллийн бүх төрлийн сүлжээ, хэрэгслээр дамжуулан олгох “Бэлэн бай” нөлөөллийн аяныг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд аймгийн 8 Гамшгаас хамгаалах алба, 10 мэргэжлийн анги нийт 18 гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чиглэлээр тодотгол хийн ажиллалаа. “Бэлэн бай” аяны хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу иргэдэд газар хөдлөлтийн аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах талаар ойлголт, мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор хүн ам олноор цуглардаг дараах газруудад “Бэлэн бай” сурталчилгааны самбарыг 6 байршилд 8 самбар байршуулан ажилласан.	100%
41	97	Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31	2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг	2023 оны “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх 01 дүгээр албан даалгаврыг гарган ариун цэврийн байгууламжийг сайжруулах чиглэлээр бүлэг заалтыг тусган сумдын гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах, эко жорлонтой болгох үүрэг чиглэл хүргүүлж, 22 нүхэн жорлонг буулгаж, Баруунбүрэн 2, Мандал 4, Алтанбулаг 2 био жорлон, Сүхбаатар сумын “Шунхлай” ШТС 1 боловсон 00-той болж, гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттай бууруулсан. Сүхбаатар суманд 19,9 сая төгрөгөөр “Био жорлон”, Баруунбүрэн	70%

		Дугаар 2019_60/40	сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	сумын "Амарбаясгалант хийд"-ийг түшиглэн отоглох цэг байгуулж, тус ажлын хүрээнд 2 ширхэг био жорлонг 59,8 сая төгрөгийн санхүүжилтээр суурилуулсан. Баянгол сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын саналыг Сангийн яаманд уламжлан 2024 оны Монгол улсын төсвийн тухай хуульд 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлуулсан. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг орчин үеийн байгууламжаар солих төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 10 сумын сургуулийн хичээлийн 12 байр, 5 дотуур байр, 4 цэцэрлэг нийт 21 объектыг шинэчлэх бөгөөд I, II ээлжид Баруунбүрэн, Цагааннуур сумын 6 объектыг сайжруулж, III ээлжид Алтанбулаг, Баянгол, Зүүнбүрэн, Хушаат сумын 9 объектын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил хийгдэж байна. 2023 онд сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн орчин нөхцөлийг сайжруулахад улсын төсвөөс 295.7 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	
	98		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Хүдэр, Ерөө, Баянгол, Мандал, Түшиг сумдад ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд ашигт малтмал боловсруулж баяжуулахад ашиглаж буй бүх усны 70 хувийг эргэлтээр дахин ашиглаж байна. Энэ арга нь алтны шороон ордыг ил аргаар боловсруулах үйлдвэрлэлд ашиглагдсан бохир усыг шүүрүүлэх далангаар дамжуулан эргэлтээр дахин ашиглаж байгаа арга юм. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих зорилгоор 2013 оны 05 дугаар сарын 16-ны А/156 тоот тушаалаар батлагдсан "Ус ашиглалтын хэрэглээг тоолууржуулах журам"-ын дагуу иргэн аж ахуй нэгжүүдэд ус ашиглалт, тоолууржуулалтын талаар зөвлөгөө өгч, 4 аж ахуй нэгж ус ашиглалтыг тоолууржуулсан.	100%
42	99	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан	Аймгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаарх 2 удаагийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэн ажилласан. Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан, Цагааннуур сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 1000 сурагчдад "Ногоон хот, ногоон барилга", "Амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт", "Байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадал" цахим сургалт, "Байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт"-ыг аймгийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн 1500 хүүхэд,	100%

			бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	17 сум 6 тосгоны 2000 иргэдийг оролцуулан зохион байгуулж, 530 ширхэг сурталчилгааны материалыг тараан зөв дадал хэвшилд сургах ажлыг хийсэн.	
43	100	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.4. Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоол, 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/282 тоот захирамжаар орон нутгийн түвшинд тариалангийн газрын нэгдсэн тооллогыг зохион байгуулж, тариалангийн газарт шилжүүлэх атар газрын хэмжээ, байршлын саналыг сумдаас авч нэгж талбар бүрээр зурагжуулан, "Тариалангийн тухай хууль"-ийн 5.1 дэх заалтын дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 01/1477 тоот албан бичгээр сумдад чиглэл хүргүүлэн ажилласан. 2022 онд нийт 205,5 мянган га талбайд тариалалт хийсэн болон 2023 онд нийт 218,2 мянган га талбайд тариалж өмнөх оны тариалалтаас 6,2 хувиар нэмэгдсэн байна.	100%
	101		3.8. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 595 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс махны чиглэлийн үхрийн аж ахуй эхлэгч иргэн, аж ахуйн нэгж 221, сүүний чиглэлийн 219 иргэн, аж ахуйн нэгж байна. Цаашид эрчимжсэн мал аж ахуйг кластерын системээр хөгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн аж ахуйн нэгжийн тоо өмнөх оноос 11,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
	102		3.10. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаар мэдээллийг түгээх зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран "Хоол хүнсний зохистой хэрэглээний талаарх сургалт"-ыг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр 15 сум 6 тосгоны 48 ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын захирал, эрхлэгч, тогооч, хоол зүйч, нярав, эмч нарын 155 гаруй төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Татварын хэлтэс, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага "Best хөтөлбөр", Галын бурхад тогоочдын холбоотой хамтран Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 43 иргэн, аж ахуйн нэгжид "Эрүүл хооллолт" сэдвээр сургалт зохион байгуулсан. Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 20 жилийн ойн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, оролцогчдын идэвх оролцоог сайжруулах, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг сурталчлах, эрүүл зохистой хооллолтыг	100%

				дэмжих, орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, төрийн үйлчилгээний байгууллагуудын тогоочдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Ургацын далай” тогоочдын ур чадварын тэмцээнийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Сүхбаатар суманд зохион байгуулсан.	
ЗГ-ын тогтоол					
44	103	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2021-07-20 Дугаар 2021_215	3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, тус үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил нарт тус тус үүрэг болгосугай.	Дархан-УБ-ын автозамын барилгын ажлыг гүйцэтгэж буй "Чайна Гео Инженеринг Корпораци" ХХК /АХБ-Багц-4, Сүмбэрийн уулзвараас Цайдмын хөндий хүртэлх зам барилгын ажилд ашигласан карьерт 18 га-д, "ГүйЖеү хайвэй инженеринг групп Монголиа" ХХК, АХБ-Багц-3, Урьханаас Бор толгой хүртэл зам барилгын ажилд ашигласан карьерт 13 га-д нөхөн сэргээлт, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд Сэлэнгэ Алтанбулаг хилийн боомтын 1.7км авто замын ажилд ашигласан карьерт 13 га-д нөхөн сэргээлт, Хүдэр сумын төвийг холбож байгаа зам бөгөөд 9.2 км зам барилгын ажилд ашигласан карьерт “ЗБИБ” ХХК 5 га-д тус тус нөхөн сэргээлтийг хийсэн. Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хайгуулын 40 тусгай зөвшөөрөл бүхий 59.0 мян.га, нутаг дэвсгэрийн 1.4 хувийг, ашиглалтын 140 тусгай зөвшөөрөл бүхий 48.0 мян.га талбай, нутаг дэвсгэрийн 1.2 хувийг, нийт 180 тусгай зөвшөөрөл бүхий 107.0 мян.га талбай, нутаг дэвсгэрийн 2.6 хувийг эзэлж байна.	100%
45	104	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар,	Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” /MNS 6395:2022/, Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага /MNS 6978:2022/-ын талаарх мэдээллийг "Хэлний бодлогын үндэсний зөвлөл"-ийн цахим хуудаснаас авч, төрийн байгууллагуудад хүргүүлэн албан бичиг, тушаалыг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих, албан тасалгааны хаяг, нэрийн хуудсыг монгол бичгээр бичих, төрийн албан хаагчдад монгол бичгийн хичээлийг түвшинд ангилан заах ажлыг ЕБС-ийн багш нартай хамтран хэрэгжүүлж байна. Насан туршийн боловсролын төв, нэгжүүд, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл бичиг, уран зохиолын багш нар байгууллагын хүсэлтийн дагуу төрийн албан хаагч, иргэдэд үндэсний бичгийн хичээлийг 3 түвшинд хуваан, 16 удаагийн сургалт, 22 уралдаан тэмцээнийг явуулж, үндэсний бичгийн түвшин ахиулах сургалтад 336 хүнийг хамруулж, унших, бичих чадварыг нэмэгдүүлсэн. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны С/13 дугаар	100%

			стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	тушаалаар Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлага MNS:6395:2022 стандартыг баталсан.	
46	105	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтыг Монгол Улсын Засгийн газар, “Удирдлагын академи”-тай хамтран 2023 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулан ажилласан. Тус сургалтад аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, төрийн байгууллагын удирдлага, төрийн албан хаагчид, ОНӨААТҮГ-ын дарга, захирлууд зэрэг 206 төлөөлөл оролцож сургагч багшаар бэлтгэгдэн, бэлтгэгдсэн төрийн албан хаагчид харьяа газар хэлтэс, өөрийн байгууллага, сумын төрийн байгууллага, иргэдэд сургалт зохион байгуулж 2400 төрийн албан хаагч, иргэдийг сургалтад хамруулан ажилласан.	100%
47	106	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд нарын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжийг гаргахаар төслийг боловсруулаад байна.	70%

			худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.		
	107		9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд нарын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 тоот тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжийг гаргахаар төслийг боловсруулаад байна.	70%
48	108	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314	2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх	Сэлэнгэ аймгийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг сар тутам шинэчлэн гаргаж, үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуй нэгжийг дэмжин ажиллаж байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг үндэслэн “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа 2023 оны 10 сарын 12-ны өдрөөс эхлэн Сэлэнгэ аймгийн сумуудаас соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн төрөл, түүвэр судалгааг нийт 10 сум 2 тосгон сонгогдож 7 ай савын хүрээнд нийт 54 өвлөн уламжлагчийг хамруулан сурвалжлан, судалгаа шинжилгээ хийж, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон	100%

			арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан тархалтыг тогтоож ажиллалаа. Үүнд: Соёлын бүтээлч үйлдвэрлэгч 11 хүнийг шинээр таньж тогтоон үйлдвэрлэл хийж байгаа газар дээр нь очиж дүрс дуу бичлэг хийж бүртгэл, баримтжуулалт хийж ажиллалаа. Ургамал түүж тан бэлтгэх, хүн анагаах арга ухаан 2 хүн, "Нэхмэл гутал урлал, годон гутал адууны ширэн гутал урлах урлаг", "Оёдол эсгүүр монгол үндэсний хувцас, дээл урлах арга ухаан", "Цагаан идээ боловсруулах арга ухаан" гэсэн 3 ай савын хүрээнд олж илрүүлэн сум, аймаг, СББӨ-ийн бүртгэл мэдээллийн улсын санд оруулан ажиллалаа.	
49	109	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Хүмүүнлэгийн үйл ажиллагааны чиглэлээрх нутгийн удирдлагын зарим чиг үүргийг Улаан загалмай хороогоор гүйцэтгүүлэхээр хамтран ажиллах гэрээний хүрээнд 105,0 сая төгрөгийн санхүүжилт, "Сэлэнгэ аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг" төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр 5.0 сая төгрөгийн санхүүжилт, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нэгдсэн холбоо" төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр 26.2 сая төгрөгийн санхүүжилт олгон ажиллаж байна. Аймгийн Ахмадын хороо төрийн бус байгууллагад 107,7 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгон нийт 4 төрийн бус байгууллагаар гэрээгээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэн нийт 243,9 сая төгрөгийн санхүүжилт олгон ажилласан байна.	100%
50	110	Орон сууцны	1.3. цэцэрлэгийн барилга	Аймгийн төв Сүхбаатар суманд баригдахаар төлөвлөгдсөн 14 блок 600	100%

	хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	айлын "Сэлэнгэ мөрөн" хотхоны 1,2 давхарт цэцэрлэг, үйлчилгээний зориулалтаар түрээслэх, худалдах талбайг оруулах саналыг тусган зураг төсвийг боловсруулж, барилгын ажлыг эхлээд байна. Тухайн онд барилгын салбарт зураг төсөл баталгаажуулах, барилгын ажил эхлүүлэхтэй, ашиглалтад оруулахтай холбоотой эрх бүхий албан тушаалтанд холбогдох зөрчил үүсээгүй байна. Мөн нэмэлтээр орон сууцны хорооллын зураг төсөл нэмж батлагдаагүй болно.	
111		1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн төв Сүхбаатар суманд баригдахаар төлөвлөгдсөн 14 блок 600 айлын "Сэлэнгэ мөрөн" хотхоны 1,2 давхарт цэцэрлэг, үйлчилгээний зориулалтаар түрээслэх, худалдах талбайг тусгах, ашиглалтад оруулах саналыг тусган зураг төсвийг боловсруулж, барилгын ажлыг гүйцэтгэж эхлээд байна. Мөн нэмэлтээр орон сууцны хорооллын зураг төсөл нэмж батлагдаагүй болно.	100%
112		2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал	2023 онд цэцэрлэгийн барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу тусган баталгаажуулж, хяналт тавин ажилласан.	100%

			тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.		
	113		3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Алтанбулаг сумын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шатанд холбогдох санал норм дүрмийн дагуу цэцэрлэг төлөвлөх талаар саналыг тусган ажилласан.	100%
	114		4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2023 онд цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх болон худалдан авах хэрэгцээ гараагүй.	100%
51	115	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга	2.7. “Алтай дайхан холдингс” ХХК-ийн газрын тусгай зөвшөөрлийг орон нутгаас хүчингүй болгосонтой холбоотой үүссэн гомдлыг судалж, хуулийн дагуу шийдвэрлэхийг	“Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 413 дугаар тогтоолын 2.7-д заасан “Алтай дайхан холдингс” ХХК-ийн ашиглахаар өргөдөл гаргасан газрыг 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан боловч Газар зохион байгуулалт, геодези зураг	100%

		хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_413	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж нарт.	зүйн газрын даргын 2023 оны 1/1683 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон тул тухайн тариалангийн зориулалттай газрыг иргэн аж ахуйн нэгжийн эзэмшил, ашиглалтад олгоогүй байна. Уг газрыг Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд баталснаар Газрын тухай хуулийн 29, 30, 31, 32, 33, 44-т зааснаар шийдвэрлэхээр ажиллаж байна.	
52	116	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Улаанбаатар хотоос шилжин ирсэн "Дэд өртөө" ХХК-ийн эрчимжсэн аж ахуйн төслийг дэмжин 95 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Улаанбаатар хотоос шилжин ирсэн иргэдийг ажиллуулж байгаа Сүхбаатар сумын "Тэнгэр баатар" ХХК, "Их тунамал цаглашгүй" ХХК, Баруунбүрэн сумын "Шинэ орос хийц" ХХК-ууд нь Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 288.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Мөн Мандал сумын "Батганбат" ХХК, Сант сумын "Сэлэнгэ таван хайрхан" дундын хоршоо нь хоршоо хөгжүүлэх сангаас 49.6 сая төгрөгийн зээл авсан. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлж, Засгийн газраас хүүгийн зөрүү 13 хувийг хариуцан олгохоор шийдвэрлэсний дагуу аймгийн хэмжээнд хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр 1 аж ахуйн нэгж 125 сая төгрөг, зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулах, газар зүйн заалт бүхий зөгийн балны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 11 иргэн 420 сая төгрөг, тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр 1 аж ахуйн нэгж 43,2 сая төгрөг нийт 2 аж ахуйн нэгж, байгууллага, 11 иргэний 588,2 сая төгрөг олгогдсон. Хоршоо хөгжүүлэх сангаас 14 сумын 9 аж, ахуйн нэгж, 4 хоршоо, 1 нөхөрлөл, 84 иргэн 1762,1 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Зээлд хамрагдсанаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж сав баглаа боодол сайжирсан. 2023 онд Улаанбаатар хотоос шилжин ирсэн 2 аж ахуйн нэгжид Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу 123 татвар төлөгчийн 1,741.8 төгрөгийн, 22.5.10 дах хэсэгт заасны дагуу 16 татвар төлөгчдөд 470.4 сая төгрөгийн хөнгөлөлт, мөн хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу 4 татвар төлөгчийн 7,8 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн.	100%
	117		4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот,	Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын	100%

			хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	“Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд хүн амынхаа тоог 20 хувиар нэмэгдүүлэх бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхтэй холбогдуулан суурь судалгааны ажлыг хийж, Улаанбаатар хотод 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Сэлэнгийн ирээдүй-Тогтвортой ногоон хөгжил” төр, хувийн хэвшлийн уулзалт, хэлэлцүүлэг, 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээг тус тус зохион байгуулан, нийт 4 өдрийн турш 1300 гаруй иргэдийг мэдээ, мэдээллээр ханган, Сэлэнгэ аймгийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг танилцуулан, улс, аймгийн цолтой 128 хүчит бөхийн барилдаан, урлаг соёлын тоглолтыг толилууллаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар бусад аймаг, нийслэлээс 1549 иргэн, 16-аас доош насны 640 хүүхэд шилжин ирсэн байна.	
53	118	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон	2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор 2023 оны аймгийн төсөвт орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 30 хувиар нэмэгдүүлэн тооцож батлуулан нийтдээ 5,2 тэрбум төгрөгийн нэмэгдэл олгосон байна. 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 118 дугаар тогтоолоор аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлж 2,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож батлуулсан.	100%

		<p>нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>		
119		<p>2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн</p>	<p>2.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах зорилгоор 2023 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 2024 онд хэрэгжүүлэх 19 төсөл, арга хэмжээний зураг төсвийн 560,0 сая төгрөгийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. 2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд 2023 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн</p>	100%

			<p>хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.</p>	<p>хөрөнгө оруулалтаар 1,3 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.1 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсч, хэмнэлтийг зарцуулахгүй байх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>2.3. 2023 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 10,4 тэрбум төгрөгийн 60 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс гүйцэтгэл 9,1 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн 8,8 тэрбум төгрөгийн 96 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 5,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан олгосон.</p> <p>2.4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан 7 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд шаардлагатай 1,6 тэрбум төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, санхүүжилтийг олгох ажлыг шуурхай зохион байгуулсан.</p> <p>2.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан ил тод нээлттэй байдлыг ханган 35 удаагийн 12,4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн болон эцсийн санхүүжилтийг олгосон.</p>	
54	120	Хяналт шалгалтын	3.Хяналт шалгалтын үйл	Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой 6 улсын	100%

		төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	байцаагч Засаг даргын Тамгын газрын орон тоон дээр нэмэгдэж, улсын байцаагч нарын хянан шалгах үйл ажиллагааны зардал болох томилолт 34.6 сая төгрөг, бичиг хэрэг 24.1 сая, тээвэр шатахуун 32.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2023 оны 07 дугаар сарын 26-ны 119 дүгээр тогтоолоор батлагдсан.	
55	121	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 37 төсөл арга хэмжээний 55,0 тэрбум төгрөг, аймгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 134 төсөл арга хэмжээний 17.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан ба жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийн материалыг Сангийн яаманд хүргүүлэн 34,3 тэрбум төгрөгийг, аймгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх 4,4 тэрбум төгрөгийг олгон ажиллаж байна.	100%
56	122	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3.Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт 14926 толгой үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.	70%
57	123	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим	Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг орон нутагт эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 оныг "Иргэдийн оролцоотой цахим хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж, мөн шилжин суурьших иргэд, аж	100%

		хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх зорилгоор huduu.mn цахим сайтад тогтмол мэдээлэл байршуулан ажиллалаа. Төрийн цахим үйлчилгээний хэлтэст тоног төхөөрөмж, тавилга авахад дэмжлэг үзүүлэхээр аймгийн хөтөлбөрийн зардлаас 23,6 сая төгрөг олгосон.	
58	124	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119	2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/272 тоот захирамж гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах насны дээд хязгаарт хүрсэн 1997 оны залуучуудаар мөнгөн төлбөр төлүүлэх арга хэмжээ авч ажилласан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 107 хувьтай биелүүлсэн.	100%
59	125	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.3.“Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт;	Аймгийн нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох зорилгоор өв соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэл, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, инновац, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийтийн биеийн тамир, санхүү, засаглал, зэвсэгт хүчин, хууль сахиулах, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлийн салбаруудыг багтаасан төлөвлөлтийг хийн ажиллаж байна. Сүхбаатар хилийн боомтын хил, гаалийн байгууллагын 3600м2 талбай бүхий 6 давхар, нэг цэгийн үйлчилгээний цогцолбор, Алтанбулаг хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажил ачаа тээврийн хэсэг болон гадна инженерийн шугам сүлжээний ажил 98 хувьтай, зорчигч тээврийн хэсгийн гүйцэтгэл 40 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд 2024 оны 1 улиралд багтаан улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	70%
	126		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус	Сум, агентлагуудаас улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний саналыг авч, Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр шивж оруулсан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд 49 төсөл арга хэмжээний 75.6 тэрбум төгрөгийн ажлууд тусгагдсан.	100%

			даалгасугай.		
60	127	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-05-17 Дугаар 2023_188	2. Батлагдсан солбицол бүхий талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржид даалгасугай.	Батлагдсан солбицол бүхий талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 6 ахуй нэгжид, ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 аж ахуй нэгжид олгосон байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон 2 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.	100%
61	128	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2023 оны 06 дугаар 21-ний өдрийн Засгийн газрын 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг тооцоолон аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тооцоолж, 2,7 тэрбум төгрөгөөр тооцоолон батлуулсан.	100%
62	129	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266	3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Улсын төсвийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн, Цагааннуур сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны 6 объектын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулсан.	100%
63	130	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	III ээлжид Алтанбулаг, Баянгол, Зүүнбүрэн, Хушаат сумын 9 объектын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил хийгдэж байна. IV ээлжид Түшиг, Ерөө сумын Бугант тосгон, Мандал сум, Орхонтуул сумын Рашаант тосгоны 6 объектын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна.	100%
64	131	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах	2.. 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг	Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын Засаг дарга нарт 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 01/404, 01/405, 01/406 албан тоотой сумын хүн амын махны хэрэгцээний 30 хувийг хаврын улирлын 3 сараар тооцоолон бэлтгэх тухай чиглэл хүргүүлсэн. Сүхбаатар, Мандал сумдын хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор 2023 оны 11 сарын	100%

		зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279	бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	24-27-ны өдрүүдэд Мандал суманд, 11 сарын 26-29-ний өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд "Өвлийн идэш" арга хэмжээг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 45 иргэн, 10 адуу, 25 үхэр, 220 хонь, 150 ямааг ченжийн гар дамжуулалгүйгээр орон нутгийн иргэдэд худалдан борлуулах ажлыг зохион байгууллаа. Үхрийн махыг 9000-9500, адууны махыг 8500, хонины махыг 8000, ямааны махыг 5500-6000 төгрөгийн ханшаар борлуулсан.	
65	132	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294	3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Аймгийн болон НҮБ-ын ХАА, экосистемийн тогтвортой хөгжлийг дэмжигч "Стрийм" төслийн санхүүжилтээр 2022, 2023 онуудад Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 17 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг иж бүрэн цогц байдлаар хийлгүүлэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас захиалагчийн хяналтыг ажлын үе шат бүрд хийж, 17 сумын ИТХ-аар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын ээлжит 18 дугаар хуралдаанаар батлуулаад байна. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, цаашид хот байгуулалтын төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөг үе шаттайгаар хийлгэх асуудлыг сумдад чиглэл хүргүүлээд байна.	100%
66	133	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304	2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2024 оны 1 дүгээр улиралд тооны хязгаарыг батлуулна.	Х.Б
67	134	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312	4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	Мэргэжлийн хяналтын газрын 6 улсын байцаагч нэмэгдэж орж ирсэнтэй холбоотойгоор холбоотойгоор 2024 оны төсвийн төсөлд 145.5 сая төгрөгөөр цалингийн санг нэмэгдүүлэн тооцоолж сангийн яаманд хянуулсан.	100%
	135		5. Худалдан авах ажиллагааны	Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ий өдрийн А/586	100%

			газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	тоот "Аймгийн Худалдан авах ажиллагааны газар байгуулах тухай" захирамжаар Худалдан авах ажиллагааны газрын бүтэц, орон тоо, дүрмийг батлуулан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн аймгийн Худалдан авах ажиллагааны газрыг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлээд байна.	
68	136	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн мэдээ, мэдээллийг цахим хуудсуудад нийтэлж, "Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих" 2 сарын аяны хүрээнд 6 удаагийн цахим сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2720 иргэнд түгээсэн. Дэлхийн Зөн ОУБ-ын Сэлэнгэ Орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Сүхбаатар сумын 1,2,3,4, Спорт сургуулийн 9-12 дугаар ангийн сурагч, Сэлэнгэ МСҮТ-ийн оюутан нийт 1003 хүүхдэд "Аюулгүй сонголт" сургалтыг явууллаа. Арьсны өвчин судлалын үндэсний төвөөс 2023 оны 11 дүгээр сарын 20-нд зохион байгуулсан "ЕБС-ийн хүүхдийг харшил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар" сэдэвт онлайн сургалтад эрүүл мэндийн хичээл заадаг 45 багш болон сургуулийн 28 эмч нийт 73 хүнийг хамрууллаа. "Боловсролын сургалтын байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээлэл, арга зүйгээр хангах" танхимын сургалтыг 2023 дүгээр сарын 02-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулахад Сэлэнгэ аймгийн төрийн өмчит сургуулийн өмнөх боловсролын 43, ерөнхий боловсролын сургуулийн 35, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн 3, нийт 81 эмч, нийгмийн ажилтны хамт хамрагдлаа. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Боловсролын ерөнхий газраас Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хөтөлбөр дэх нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн цогц боловсрол олгох агуулга, аргазүйг нийт эрүүл мэндийн багш нарт олгох зорилготойгоор "Бэлгийн цогц боловсрол"-ын агуулгыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулахад Боловсрол, шинжлэх ухааны газрын Биологи, эрүүл мэндийн судлагдахуун хариуцсан мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдлээ. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын газар, Засаг даргын Тамгын газар, сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд "Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинж", "Бэлгийн замаар дамжих халдвар	100%

				өнөөгийн байдал сэргийлэх арга хэмжээ", "Хүүхдийн хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ" зэрэг сэдвээр 140 иргэнд сургалтыг зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар түгээн ажилласан.	
69	137	"Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Цэцэрлэгүүд өдрийн дэглэмийн дагуу өглөө, өдрийн хоолны дараа шүд угаах цагийг хэрэгжүүлэн ажилладаг. Ерөнхий боловсролын сургуулиудад эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчин бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт, шүд угаах цаг гаргах ажлыг хэрэгжүүлэхэд 2024 оноос шаардагдах хөрөнгийг шийдэн, үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.нг	70%
70	138	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Сүхбаатар, Мандал сумдад хүн амын махны хэрэглээг хангах зорилгоор "Өвлийн идэш" арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 45 иргэн 10 адуу, 25 үхэр, 220 хонь, 150 ямааг хэрэгцээлж, чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, бэлтгүүлэн орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээнд худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан.	100%
71	139	Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон) 2023-11-22 Дугаар 2023_411	9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж	Сэлэнгэ аймагт хамааралгүй заалт тул хэрэгжээгүй болно.	Х.Б

			ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.		
72	140	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449	3.. 3 .Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын "Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай" 449 дүгээр тогтоолын дагуу улсын нөөцөөс тэжээл хуваарилагдаагүй. Аймгийн хэмжээнд 2023 онд 165.5 мян.тн өвс, 1000 тн сүрэл, 14.4 мянган тн ногоон тэжээл, 34.5 мянган тн үйлдвэрийн тэжээл, 5.5 мян.тн дарш, 80 тн гар тэжээл, 3.9 мянган тн эрдэс тэжээлийг бэлтгэн, хэрэгжилт 97.2 хувьтай, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 65,9 хувьтай тус тус бэлтгэсэн.	100%
73	141	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456	1.1.. 1 .Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 1.1. .Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явЦ байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар 39 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийг "Барилгын тухай хууль", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмыг баримталж хяналт тавин заавар зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан, эрх шилжсэн 12 төсөл, арга хэмжээний 12,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан.	100%
	142		1.2.. 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжилт олгогдоогүй 13 төсөл арга хэмжээний 1.2 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар тогтоолыг үндэслэн барьцаа дансандаа байршуулан ажилласан.	100%

			санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;		
	143		1.3.. 1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар тогтоолыг үндэслэн Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олгогдоогүй 13 төсөл арга хэмжээний 1.2 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр олгохоор төлөвлөсөн.	100%
74	144	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457	2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Орон нутгийн хөгжлийн сангаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймгуудад нэмэлтээр хуваарилагдаж, үүнээс сумдад олгох санхүүжилтийг 60 хувьд хүртэл нэмэгдүүлж, ингэснээр тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулан, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх боломж бүрдэж байна. 2024 оны Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 142 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг нийтдээ 26.5 тэр бум төгрөг буюу аймагт 9.6 тэр бум, сумдад 16.8 тэр бум төгрөг тус тус хуваарилагдан батлагдсан.	100%
75	145	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458	2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	"Go Mongolia" арга хэмжээний хүрээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор "Go Selenge", "Yeruu CUP" болон "Улсын мөсөн сурын харваа"-ны тэмцээнийг 2 дугаар сард тус тус зохион байгуулан ажилласан.	100%
76	146	Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай	4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга	Сүхбаатар, Мандал сумдад хүн амын махны хэрэглээг хангах зорилгоор "Өвлийн идэш" арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 45 иргэн 10 адуу, 25 үхэр, 220 хонь, 150 ямааг ченжийн гар дамжуулалгүйгээр чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган бэлтгүүлж, орон нутгийн иргэдэд худалдан	100%

		2023-12-20 Дугаар 2023_461	нарт даалгасугай	борлуулах ажлыг зохион байгуулсан.	
77	147	2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481	4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах ажилд санал өгөх ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах уриалгыг сумдын Засаг дарга, агентлагийн дарга, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад хүргүүлж, гарсан санал хүсэлтийг нэгтгэн, холбогдох тооцоо судалгааг хийж, зохих байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.	100%
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
78	148	2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36	XII.11.4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын орчин нөхцөлийг сайжруулах, сурагч, багш, ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Япон улсын "Өвсний үндэс-Хүний эрүүл мэнд" хөтөлбөрийн хүрээнд 600.0 сая төгрөгийн төсвөөр Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
79	149	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58	XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх	Эрүүл мэндийн 2 барилга, орон сууцны 29 барилга, боловсролын 8 барилга, соёлын төвийн 5 барилга, конторын 3 нийт 47 барилга	100%

		дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	байгууламж газар хөдлөлтөд тэсвэргүй ашиглалтын шаардлага хангахгүй байгаа судалгаатай ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын орчин нөхцөлийг сайжруулах, сурагч, багш, ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Япон улсын "Өвсний үндэс-Хүний эрүүл мэнд" хөтөлбөрийн хүрээнд 600.0 сая төгрөгийн төсвөөр Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд их засварын ажил хийж дууссан.	
80	150	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63	ХҮ.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт;	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөцийн судалгааг долоо хоног бүр Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд мэдээлэн ажиллаж байна. Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, татан авалт хэвийн явагдлаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар зах зээлд үхрийн мах 10,0-11,0 мянган төгрөг, хонины мах 8.5-9.0 мянган төгрөг, ямааны мах 7.5-8.0 мянган төгрөг, гахайн мах 11.0-12.0 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна. Сэлэнгэ аймгийн төв болон Мандал сумын төвийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор 2023 оны 11 сарын 24-27-нд Мандал суманд, 11 сарын 26-29-ний өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд өвлийн идэш арга хэмжээг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 45 иргэн, 10 адуу, 25 үхэр, 220 хонь, 150 ямааг ченжийн гар дамжуулалгүйгээр орон нутгийн иргэдэд худалдан борлуулах ажлыг зохион байгууллаа.	100%
81	151	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	ХИҮ.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө	2023 оны жилийн эцсийн байдлаар зах зээлд худалдаалагдаж буй махны үнэ:үхрийн мах 10,0-11,0 мянган төгрөг, хонины мах 8.5-9.0 мянган төгрөг, ямааны мах 7.5-8.0 мянган төгрөг, гахайн мах 11.0-12.0 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна. Сүхбаатар сумын иргэдийн хаврын улирлын хэрэгцээний махны нөөцийг "Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ" ОНӨААТҮГ нь бүрдүүлэхээр ямааны мах 7395 кг, хонины мах 3500 кг-ийг нөөцлөн, 4 дүгээр сараас эхлэн хонины махыг нэг кг нь 8000, ямааны махыг нэг кг нь 7000 төгрөгөөр тус тус худалдан борлуулсан. Хаврын хэрэгцээний нөөц хомсдож, үнийн хөөргөдөл үүссэн тул улсын нөөцийн махнаас татан авах хүсэлтийг ХХААХҮ-ийн сайд Х.Болорчулуунд хүргүүлэн ажилласан.	100%

			газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;		
	152		ХИҮ.7.7. Нийлүүлэлт нь хүндэрч болзошгүй бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай тээвэр, логистикийн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Нийлүүлэлт нь хүндэрч болзошгүй бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн судалгааг сумдаас авч нэгтгэн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Мөн сумдад гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх зорилгоор томоохон дэлгүүрүүдтэй нөөцийн гэрээ байгуулан ажиллаж байна.	100%
82	153	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	ХИҮ.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хот, суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг тогтоох ажлыг хэрэгжүүлэх хүрээнд 17 сумын одоо байгаа 24 байршилд 32.4 мян.га, шинэ суурьшил үүсэх 35 байршилд 15,3 мян.га газрыг шинэчлэн тогтоож аймгийн ИТХ-ын 2023 оны ээлжит 19 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 145 тоот тогтоолоор батлуулан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэв.	100%
83	154	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар,	Сүхбаатар, Цагааннуур суманд нийтийн эзэмшлийн гудамж талбай байгуулах, гэрэлтүүлэг тавих, явган хүний зам тавих зэрэг ажил хийсэн. Аймгийн хэмжээнд 7873 м2 цэцгийн мандал, 1589 м2 талбайд зүлэгжүүлэлт, 7 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 36 нэрэмжит төгөл байгуулж, ойжуулалтыг ажлыг 500 га талбайд 1.5 сая ширхэг тарьц, ойн зурвас 25,3 га талбайд 14.0 мянган ширхэг суулгац нийт 398.3 мянган ширхэг мод тарихад 1,2 сая төгрөгийн аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгөөр зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын төв дотор гурвалжингийн уулзвараас Номин буудлын уулзвар хүртэлх 400 метр урт 4 эгнээ зам, замын далангийн ажил бүрэн ажиллагаанд орсон. Ерөө суманд 4 км дугуйн зам тавих ажил хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан.	100%

			Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав;		
	155		XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Иргэдэд тоон гарын үсэг олгох, тоон гарын үсгийн хэрэглээг сурталчлан таниулах ажил өдөр бүр хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 27,948 иргэнд тоон гарын үсэг олгоод байна.	100%
84	156	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	ХҮИИ.3.1.4. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж, газрын асуудал болон эрх хэмжээний хүрээнд хамаарах тусгай зөвшөөрөл олгох, төлбөр, хураамж авах, хэлцэл хийхтэй холбоотой асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга	Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхээр заасан байгаа тул нийслэлээс шилжин ирсэн аж, ахуйн нэгжийн газартай холбоотой өргөдөл хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулан тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар бүх сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлсэн. Улсын тэмдэгтийн тухай хуулийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн	100%

			нарт;	хураамжийн хэмжээг тогтоон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 146 дугаар тогтоолоор батлуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн дагаж мөрдөн ажиллаж байна.	
85	157	2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41	<p>ҮИИ.6. “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав:</p> <p>1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх;</p> <p>1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх;</p> <p>1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх;</p> <p>1.4. Улсын Их</p>	<p>Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний Сэлэнгэ аймагт хамааралтай нийт 94 зорилтын 185 арга хэмжээг хяналтдаа авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Япон улсын “Өвсний үндэс-Хүний эрүүл мэнд” хөтөлбөртэй хамтран 600.0 сая төгрөгийн төсвөөр Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд “Оргил Таур” ХХК нь их засварын ажлыг хийж гүйцэтгэж, улсын комисс хүлээлгэн өгсөн.</p> <p>Төр, хувийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар суманд шинээр баригдах 50 мВт-ын дулааны цахилгаан станцын Техник эдийн засгийн үнэлгээг боловсруулж, дулааны цахилгаан станцын шавийг тавьж, Сүхбаатар суманд 950 айлын “Сэлэнгэ мөрөн”, “Сүлд өргөө” хотхоны барилгын төслийн хэрэгжүүлэн барилгын ажлыг эхлүүлсэн.</p> <p>1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 55,0 тэрбум төгрөгийн 39 төсөл арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.</p>	100%

			Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх.		
86	158	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	“Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээ”-ний 6 багц үзлэгийг анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагуудад аймгийн хэмжээний 107889 иргэнд зохион байгуулахаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт тус тус Эрүүл мэндийг дэмжих төвийг 2022 онд байгуулсан. Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар хамрагдалт 31 хувь байгаа бөгөөд хүүхдийн 0-17 насны 2 багц үзлэг, оношилгоонд 37981 хүүхэд хамруулахаас 25507 хүүхэд хамруулсан. Хамралтын хувь 67,2 хувь байна. Насанд хүрэгчийн 4 багцын 69918 иргэн хамруулахаас 8917 насанд хүрсэн иргэн хамруулсан. Хамралтын хувь 12,7 хувь байна.	100%
87	159	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын	Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 35 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллага, ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехникийн коллеж үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд аймгийн хэмжээнд боловсролын салбарт шинээр ашиглалтад орж байгаа барилга, байгууламжийг орон нутгийн өмчит бүртгэгдэж буй тухай бүрт газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлж, тухайн байгууллагын баланст бүртгэгдэж байна.	100%

			сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.		
88	160	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.5. . Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт;	Мал эмнэлгийн нийт 786 цахим гэрчилгээгээр 6803 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн. Үүнээс өөр аймаг сум руу мал эмнэлгийн 449 цахим гэрчилгээгээр 3945 толгой мал амьтан /отор-36, мал хэрэгцээлэх-3625 үржил-284/ явсан, өөр аймаг сумаас мал эмнэлгийн 197 цахим гэрчилгээгээр 1518 толгой мал, амьтан /отор-47, мал амьтан хэрэгцээлэх-1208 үржил-263/ ирсэн, аймаг дотроо мал эмнэлгийн цахим 140 гэрчилгээгээр нийт 1340 толгой мал, амьтан /отор-7, үржил-159, мал, амьтан хэрэгцээлэх-1174/ шилжилт хөдөлгөөн хийхэд хяналт тавьж баталгаажуулан ажилласан. Мал эмнэлгийн цахим гэрчилгээг Мал эмнэлгийн нэгдсэн систем-2.0 системээр дамжуулан олгож, хяналт тавьж баталгаажуулдаг.	100%
	161		XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион	Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (egr.e-mongolia.mn)-ээр дамжуулан аймгийн хэмжээнд албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллах талаар 17 сум, 6 тосгод, газар, хэлтэс, албадад чиглэл өгч, бэлтгэл ажлыг ханган аймгийн хэмжээнд нэвтрүүлж эхэлж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, E-Mongolia академитай хамтран иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх 17 сумын операторуудыг	100%

			байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	чадавхжуулсан. Төрийн цахим үйлчилгээний хэлтэс орон нутагт байгуулагдаж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн. Иргэдэд "Хурдан" төвөөр дамжуулан 39 байгууллагын 440 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна.	
89	162	2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2023-01-05 Дугаар 2023_2	IV.2.3. хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг, дүүрэг, сум, хороонд байгуулан ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Сэлэнгэ аймгийн хэмжээнд Халамжийн нэгдсэн систем E-halamj.mn-нд бүртгэлтэй 38100 хүүхэд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжид 100 хувь хамрагдаж байна. 2023 оны 01 дүгээр сараас амьжиргааны түвшнээс хамааран зогсоогдсон хүүхдүүдээс давхардсан тоогоор 12950 хүүхдийн 01-06 дугаар сарын хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нөхөн олгосон болно. /Цаашид хяналтаас хасуулах саналтай./	100%
90	163	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд нарын хамтарсан 2022 оны 95/260 тоот тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам" -ын дагуу аймгийн Засаг даргын захирамжийг гаргахаар төслийг боловсруулан ажиллаж байна.	100%
91	164	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIV.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар,	Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн систем /sudalгаа.gov.mn/-д байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхдөлд хариуцуулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын захиалгаар хийлгэсэн "Хөрсний доройтлын судалгаа", Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын "Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа" нийт 2 судалгааг байршуулан ажилласан.	100%

			төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;		
92	165	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	IX.2. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 21 төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын 63.3 тэрбум төгрөгийн батлагдсан ажлаас 2023 онд 33.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон.	100%
93	166	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 706.6 мянган толгой мал, амьтан хамруулахаас 701.7 мянган толгой мал, амьтан хамруулж, 99.3 хувьтай, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1.4 сая толгой бог малыг хамруулахаас 1.4 толгой бог малыг хамруулж 99.8 хувьтай, бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, сорил шинжилгээнд давхардсан тоогоор 1.5 сая толгой мал, амьтан хамрагдахаас 1.5 сая толгой мал, амьтан хамрагдаж, 99,7 хувьтай, шимэгчтэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 6.1 сая толгой мал, амьтан давхардсан тоогоор хамрагдаж, аймгийн хэмжээнд технологит хугацаанд нь давхардсан тоогоор 5.8 сая толгой мал, амьтан хамруулж, 95.3 хувьтай зохион байгуулж, "Гоц халдварт өвчингүй тайван бүс нутаг" хэвээр хадгалсан.	100%
94	167	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендерийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендерийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендерийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөдөлгөөнийг бэхжүүлэх "Нэг тэрбумаараа тэмцье 2023" алхалтын арга хэмжээг зохион байгуулж 100 иргэнийг хамруулсан. Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгаж, тэгш эрхийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төр, төсвийн 27 байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг хөдөлмөрийн дотоод журамдаа тусган ажиллаж байна. "Тэгш боломжийн төлөө залуусын манлайлал" сургалтыг 10 сэдвийн хүрээнд 4 сумын 18-34 насны 285 залуучуудад зохион байгуулсан. "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулан 22 байгууллага нэгдэж "Хүндлэл хамгийн тод гэрэл" постерийг байрлуулан, мэдээлэл түгээж ажилласан. Үр дүн: 37 удаагийн сургалт, 2 аян, 3 нөлөөллийн	100%

				арга хэмжээ зохион байгууллаа.	
	168		XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхээр 2023 оны 4 дүгээр сараас Мандал сумын Нэгдсэн эмнэлэг ходоодны уян дурангийн аппаратыг түрээсийн журмаар ажиллуулж, Эрүүл мэндийн даатгалын газартай гэрээ байгуулан амбулатори болон эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%
95	169	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13	IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 3016 иргэнд 615.28 га газрыг өмчлүүлэхээр санал уламжилсан нь Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолоор албажиж тайлант хугацаанд шинээр 393 иргэнд 60.23 га, одоо эзэмшиж байгаа 0.75 га газрыг 8 иргэнд тус тус өмчлүүлсэн бөгөөд эдгээр олгосон газар нь хууль тогтоомжоор хориглосон болон бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгосон газартай ямар нэгэн хэмжээгээр давхцаагүй байршилд өмчлүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 1/2878 тоот албан бичгээр “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем дээр шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоож, мэдээллийн санд хаалт хийж ажиллах” чиглэлийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсний дагуу 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс шинээр газар олгох үйл ажиллагааг зогсоосон байна.	100%

			Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.		
96	170	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/17 дугаартай зөвлөмжийг хүлээн авч танилцан холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтан нарын үйл ажиллагаанд анхаарч албан бичиг хүргүүлэн сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэн зөвлөмжийн хариуг Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулагдаагүй.	100%
97	171	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон Онцгой байдлын газар, хэлтэс, анги салбарын авч хэрэгжүүлж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 2023 оны жилийн эцсийн байдлаар Онцгой байдлын газрын sea.nema.gov.mn цахим хуудсанд 217 удаа, facebook.com/selengeobg олон нийтийн сүлжээнд 297 мэдээ, 181 сэрэмжлүүлэг нийт 695 удаа байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан түгээж ажилласан.	100%
98	172	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
99	173	2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр	XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах,	Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүсээгүй тул 2023 онд гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажил	100%

		22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22	устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	хийгдээгүй болно.	
100	174	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудас /selenge.gov.mn/-т болон мэдээллийн нэгдсэн систем /shilen.gov.mn/-д байршуулан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “5Ш ажиллагаа”-ны хүрээнд “Шил” ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллахдаа аймгийн албан ёсны цахим хуудсанд тогтоолыг хэрэгжүүлэх журмын хавсралтад заагдсан 6 зүйл 98 заалтын хэрэгжилтийг хангуулан shilen.gov.mn цахим хуудсанд 96,3 хувийн үзүүлэлттэй, улсад 6-д эрэмбэлэгдэж байна.	100%
101	175	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр	XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Нээлттэй	100%

		25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	Сэлэнгэ” арга хэмжээг Улаанбаатар хотноо 1300 гаруй иргэдийг оролцуулан зохион байгуулж, аймгийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд, цаашдын хөгжлийн чиг хандлага, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан. “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлогын богино хугацааны сургалт”, “Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах богино хугацааны сургалт”-ыг зохион байгуулж, 206 албан хаагчдыг танхимаар, 2000 иргэдийг цахимаар оролцуулж, сургагч багш бэлтгэн орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг бэлтгэсэн.	
	176		XIII.5.3. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайллаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайллаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажилласан.	100%
	177		XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	Сэлэнгэ аймаг 2023 оны "Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил" болгон зарласан. “Цахим аймаг бодлогын зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэг Сэлэнгэ аймагт 2023 оны 10 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд ажилласан. Сэлэнгэ аймагт одоогоор “ХУРДАН” цэг хоёр байрлалд ажиллаж байна. “И-Монгол академи” УТҮГ-ын Салбар дундын зохицуулалтын газрын процесс аналит Г.Буднямаар ахлуулсан баг Сэлэнгэ аймагт 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ний өдрүүдэд ажилласан. E-Mongolia систем дэх орон нутгийн үйлчилгээнүүдийг дахин загварчилж, шинээр нэвтрүүлэх үйлчилгээг судлах ажлын хүрээнд 11 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 23-ны хооронд Сэлэнгэ аймгийн 25 байгууллагатай уулзалт хийж, эдгээр байгууллагын цахимаар үзүүлдэг 73 үйлчилгээний процессын судалгааг авч, 7 шийдвэрлэх албан хаагчийн эрхийн тохиргоо болон мэдээллийг шинэчиллээ.	100%
102	178	2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр	XV.1.3. Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан дулаан	Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан үнэ тарифын өөрчлөлт нь төсвийн тухай хуулийн 8.4.3-д заасны дагуу тухайн жилийн төсвийн	100%

		37 дугаар тэмдэглэл 2023-09-13 Дугаар 2023_37	хангамжийн үнэ тарифыг мөрдөөгүйгээс төсөвт байгууллагуудад үүссэн өр төлбөрийг 2024 оны улс, орон нутгийн төсөвт тусган батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсний дараа ирсэн бөгөөд Сангийн яамнаас 2024 оны төсөвт тусгагдаж ирээгүй. 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тодотгосон төсвийн 18-р тогтоолоор Алтанбулаг сумын сургууль цэцэрлэгт 114,9 сая төгрөг, Баянгол сумын сургууль цэцэрлэгт 104,7 сая төгрөг, Шаамар сумын сургууль цэцэрлэгт 97,4 сая төгрөг, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 39 сая төгрөг буюу нийтдээ 356,1 сая төгрөгийг тооцоолж нэмэгдүүлэн батлуулсан. Төсвийн жилд тогтмол зардал 1.8 тэрбум төгрөгөөр хянагдан энэ онд 216.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18 дугаар хуралдаанаар 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан.	
103	179	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	XVIII.8.1. 1. Ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах, ургацыг цаг агаарын гамшигт үзэгдэл болон малаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг тариалан бүхий аймгийн Засаг дарга нарт;	Сумдад чиглэл хүргүүлэн, улсын байцаагчийн зөвлөмжийг өгч ажилласан. Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орж хохирол учруулсан 10 гомдлыг шийдвэрлэсэн. 2023 онд нийт 16234 га талбайг хашаажуулсан.	100%
	180		XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 18 төсөл арга хэмжээ шилжиж, 67.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан, Аймгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 22 төсөл, арга хэмжээ шилжиж, 4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэл хяналт тавих ажлыг үе шаттай зохион байгуулж ажилласан.	100%
	181		XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт	2023 оны барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд барилгын гүйцэтгэлд захиалагчийн хяналтын байгууллагаас хяналт, шалгалт хийн ажиллахад гэрээний дагуу ажлыг гүйцэтгэж байгаа тул гэрээ цуцлах арга хэмжээгүй авагдаагүй болно.	100%

	182		XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 13 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн гэрээнд заасан хугацаандаа ажил үүргээ гүйцэтгээгүй 13 аж ахуй нэгжийг Сангийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж, хар жагсаалтад оруулах хүсэлт өгч ажилласан.	100%
	183		XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	2024 оны улсын төсвөөр батлуулах 78 төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны цахим системд https://pimis.publicinvestment.gov.mn/ байршуулан шивж оруулснаас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд зураг төсөл нь батлагдсан, дэд бүтэц, газрын зөвшөөрөлтэй шинээр 16 төсөл арга хэмжээ батлагдсан.	100%
104	184	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт;	Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, "Нээлттэй Сэлэнгэ" аймгийн хөтөлбөрт тусган хэрэгжилтийг ханган, шилжин суурьших хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Ипотекийн зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн 18 орчим хувийг орон нутагт олгож, жилд ойролцоогоор 1,900 орчим өрх тус хөнгөлөлттэй зээлд хамрагддаг байна. Тэгвэл 2024 оноос эхлэн ипотекийн зээлийн эх үүсвэрийг орон нутагт тэгш хүртээмжтэйгээр үе шаттайгаар нэмэгдүүлснээр орон нутагт орон сууцны нийлүүлэлт нэмэгдэж, илүү олон өрх орон сууцад хамрагдах нөхцөл бүрдэх юм.	100%
	185		2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг	Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралд танилцуулсан.	70%

			шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;		
	186		2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, аймгийн баяр наадмын зардалд орон нутгийн хөгжлийн сангаас 200.0 сая төгрөгийг төсөвлөн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18 дугаар хурлаар батлуулсан.	100%
	187		2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.new.unelgee.gov.mn)-д байршуулж, ажилласан.	100%
105	188	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41	XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Аймгийн Засаг даргын “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай” 2023 оны 01 дүгээр албан даалгаврын дагуу 5542.4 тн аюултай хог хаягдал тоологдож аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Түмэн эгшиг” ХХК, “Цэцүүх” ХХК-аар устгуулсан.	100%
106	189	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан судлан ажиллаж байна.	70%

			ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;		
107	190	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49	XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.”	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Ган, зудын байдалд үнэлгээ хийх журмын дагуу аймгийн хэмжээнд Сүхбаатар, Хүдэр сум, Бугант тосгоны нутгаар цагаан зуд, Түшиг, Цагааннуур, Хушаат, Орхон, Орхонтуул, Зүүнбүрэн, Баянгол сумдын нутгаар Цагаанаар зудархуу байна. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ажиллаж байх үүрэг чиглэлийг 17 сум, 6 тосгодод өгч ажилласан.	100%
	191		XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Сүхбаатар сумын иргэдийн хаврын улирлын хэрэгцээний махны нөөцийг “Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар нь бүрдүүлэхээр ямааны мах 7395 кг, хонины мах 3500 кг-ийг нөөцлөн, 4 дүгээр сараас эхлэн хонины махыг нэг кг нь 8000, ямааны махыг нэг кг нь 7000 төгрөгөөр тус тус худалдан борлуулсан. Хаврын хэрэгцээний нөөц хомсдож, үнийн хөөргөдөл үүссэн тул улсын нөөцийн махнаас татан авах хүсэлтийг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд хүргүүлэн ажилласан. Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын Засаг дарга нарт Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2023 оны 01/404, 01/405, 01/406 тоот албан бичгээр сумын хүн амын махны хэрэгцээний 30 хувийг хаврын улирлын 3 сараар тооцоолон бэлтгэх чиглэл хүргүүлсэн боловч нөөцийн мах бэлтгээгүй.	100%
108	192	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51	XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Аймгийн Засаг даргын 2022 оны А/229 тоот захирамжийн дагуу эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 17 сум, 6 тосгоноос сар бүр 15-20 хүнийг бүрдүүлэн хуваарийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлгүүдэд насанд хүрэгчийн багц үзлэгт хамруулах, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулахад онцгой анхаарч, цалинтай чөлөө олгох, унаагаар үйлчлэх зэргээр байгууллагууд, сумын дарга үүрэг болгож ажилласнаар Эрүүл мэндийн дэмжих төвийн үйл ажиллагаа тогтмол, тасралтгүй, хүлээгдэл чирэгдэлгүй ажиллаж байна.	100%
	193		XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн 16 сумын 44 багийг тариалангийн бүс нутаг болгон зарласан. Үүнтэй холбогдуулан газар тариалангийн бүс нутагт бусад аймаг сумдаас мал оруулахгүй байх, гаднаас малтай айл өрх шилжин ирэхийг	100%

			<p>зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав</p>	<p>хориглож бусад аймаг сумдаас отроор мал өвөлжүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. Бусад аймаг, сумаас манай аймагт отроор орж ирж өвөлжиж байгаа малчин өрх байхгүй. Мөн бусад аймаг, сум руу манай аймгаас отроор гарсан малчин өрх байхгүй. Харин Мал эмнэлгийн цахим гэрчилгээгээр өөр аймаг сум руу 36 толгой мал отрын зорилгоор гарсан бол өөр аймаг сумаас 47 толгой мал отроор нэвтэрсэн. Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн системээр дамжуулан мал, амьтны шилжилт хөдөлгөөн болон мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зориулалтаар нийт 27,5 мянган мал эмнэлгийн гэрчилгээ олгож, 1,8 мянган гэрчилгээгээр 28,6 мянган толгой мал, амьтан, шилжилт хөдөлгөөн хийж, 2023 онд өмнөх оноос 43,7 мянган толгойгоор буюу 2,5 дахин буурсан. Мал эмнэлгийн гэрчилгээгүй орж ирсэн 6 иргэний 3,1 мянган толгой мал, амьтныг буцааж, мал эмнэлгийн цахим системээр дамжуулан өөр аймаг сумд, эрсдэлтэй бүсээс шилжилт хөдөлгөөн хийх 148 хүсэлтэд татгалзаж хяналт тавьсан. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтын явцад мал эмнэлгийн гэрчилгээгүй, мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийсэн 1 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж, 500,0 мянган төгрөгийн, 2 иргэнд хялбаршуулсан журмаар 150,0 мянган төгрөгийн нийт 650,0 мянган төгрөгийн тус тус торгуулийн арга хэмжээ авч хариуцлага тооцсон.</p>	
194			<p>ХХV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Аймгийн Засаг даргын 2023 оны “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх 01 дүгээр албан даалгавраар агаар, хөрс, усны бохирдлын ерөнхий үнэлгээг 14 аж ахуйн нэгжид хийж, агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 17 сумын 138 аж ахуйн нэгжийг хамруулан аймгийн хэмжээнд ердийн галлагаатай 3-15 квт хүртэл хүчин чадалтай зуух хэрэглэдэг 13.6 мянган айл өрх тоологдож, 23.5 мянган тн нүүрс, 73.7 мянган м³ мод түлш хэрэглэсэн нь өмнөх оныхоос нүүрс 30.2 хувиар, модны хэрэглээ 31.1 хувиар тус тус буурсан байна. Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор эко жорлонтой болгох арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл хүргүүлж, Баруунбүрэн 2, Мандал 4, Алтанбулаг 2 био жорлон, Сүхбаатар сумын “Шунхлай” ШТС 1 боловсон жорлон ашиглалтад оруулсан. Энэ онд 17 сумын төр төсвийн 161 байгууллага, 258 аж ахуйн нэгж, 1278 өрхийн 3825 иргэд 412,3 тн хог хаягдал цэвэрлэж, Баруунбүрэн, Сант, Орхон сум нар төвлөрсөн хог хаягдлын 6.7 га талбайг түрж хумьж, цэгцлэн, булшилж, Сант сум хогийн цэгийн хашаажуулалт, тохижилтын ажлыг хийсэн.</p>	100%

	195		XXV.3.2.11.. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 143 дугаар тогтоолоор батлуулж, нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоон Сүхбаатар сумын 7-р багт 12 давхар бүхий 3 блок 336 айлын "Сүлд өргөө" хотхон, Сүхбаатар сумын 4 дүгээр багт 600 айлын "Сэлэнгэ мөрөн" хотхоныг барих барилгын төслийн ажлыг эхлүүлсэн. Зүүнбүрэн суманд 4 айлын амины орон сууцыг ашиглалтад орсон.	100%
ЗГ-ын албан даалгавар					
109	196	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харьяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтыг Монгол Улсын Засгийн газар, "Удирдлагын академи"-тай хамтран 2023 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулан ажилласан. Тус сургалтад аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, төрийн байгууллагын удирдлага, төрийн албан хаагчид, ОНӨААТҮГ-ын дарга, захирлууд зэрэг 206 төлөөлөл оролцож сургагч багшаар бэлтгэгдэн, бэлтгэгдсэн төрийн албан хаагчид харьяа газар хэлтэс, өөрийн байгууллага, сумын төрийн байгууллага, иргэдэд сургалт зохион байгуулж 2400 төрийн албан хаагч, иргэдийг сургалтад хамруулан ажилласан.	100%
110	197	Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2022-07-28 Дугаар 2022_7	4. Монгол Улсын болон орон нутгийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 80-с дээш хувийн гүйцэтгэлтэй боловсролын байгууллагын барилга байгууламжийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор ашиглалтад бүрэн оруулах арга хэмжээ авах, гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг саадгүй олгох, шаардлагатай тохиолдолд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан нэмэлт зардлыг 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх	Монгол Улсын 2023 оны төсвийн 3,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан 80-с дээш хувийн гүйцэтгэлтэй Ерөө сумын 200 ортой цэцэрлэгийг ашиглалтад оруулж, тухайн оны 900 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100%

			ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;		
111	198	2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай 2022-08-01 Дугаар 2022_9	<p>3. 3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:</p> <p>3.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц”-ийг тогтоосон хэмжээнд бүрдүүлж ажиллах;</p> <p>3.2. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;</p> <p>3.3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн амыг чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангах, өвөл, хаврын улирлын хэрэгцээнд шаардагдах махны нөөцийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, нөөцийн махны чанарт онцгой анхаарч ажиллах;</p> <p>3.4. Малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийлгэж, Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p>	<p>3.1. Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 160.9 мянган тн байгалийн хадлан, 46,5 мян.тн хүчит тэжээл, 5,8 мян.тн эрдэс тэжээл бэлтгэхээс 165.5 мян.тн өвс, 1000 тн сүрэл , 14.4 мянган тн ногоон тэжээл , 34.5 мянган тн үйлдвэрийн тэжээл, 5.5 мян.тн дарш, 80 тн гар тэжээл, 3.9 мян.тн эрдэс тэжээл бэлтгэж өвс, тэжээл бэлтгэлийн ажлыг 97.2 хувьтай хангаад байна. Сумдын аюулгүйн нөөцөд 1020 тн өвс, 680 тн тэжээл бэлтгэхээс 825 тн өвс, 460 тн тэжээл бэлтгэсэн нь 65,9 хувьтай байна.</p> <p>3.2. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах талаар 2023-2024 оны өвөл, хаврыг өнтэй давах, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай, Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс бүрдүүлэх тухай зэрэг заавар, зөвлөмжөөр хангаж ажилласан.</p> <p>3.3. Сүхбаатар сумын иргэдийн хаврын улирлын хэрэгцээний махны нөөцийг “Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар нь бүрдүүлэхээр ямааны мах 7395 кг, хонины мах 3500 кг-ийг нөөцлөн, 4 дүгээр сараас эхлэн хонины махыг нэг кг нь 8000, ямааны махыг нэг кг нь 7000 төгрөгөөр тус тус худалдан борлуулсан.</p> <p>3.4. Аймгийн хөрөнгө оруулалтаар 10 суманд 11 ширхэг арьс ширний анхан шатны боловсруулалт хийх сойзон махлагчтай тоног төхөөрөмжийг авч нийлүүлсэн. Мөн арьс ширний мөшгөх системийн сургалтад арьс шир хүлээн авагч төвүүдийн нийт 12 ажиллагсдыг хамрууллаа. Малын арьс шир авах 13-н цэг ажиллаж байна. Сант, Орхонтуул сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас 2 иргэн, 1 хоршоонд малын гаралтай түүхий эд хүлээн авах, борлуулах цэг байгуулах чиглэлээр нийт 110 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Арьс ширний боловсруулалт хийх 3 цех шинээр байгуулагдаж, үндэсний үйлдвэрт тушаасан арьс ширний хэмжээ 16 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>3.5. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн 16 сумын 44 багийг тариалангийн бүс нутаг болгон зарласан. Үүнтэй холбогдуулан газар тариалангийн бүс нутагт бусад аймаг сумдаас мал оруулахгүй байх, гаднаас малтай айл өрх шилжин ирэхийг хориглож бусад аймаг сумдаас отроор мал өвөлжүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна.</p>	100%

		<p>3.5. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц газрын хил заагийг тодорхойлж, харьяалах аймаг, сумдад өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>3.6. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах асуудлын хүрээнд говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан, гар тэжээл бэлтгэхэд нь зохих дэмжлэг үзүүлж ажиллах;</p> <p>3.7. Орон нутагт хийгдэж байгаа инженерийн хийцтэй худгийн чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;</p> <p>3.8. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах;</p> <p>3.9. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу шуурхай авч хэрэгжүүлэх;</p> <p>3.10. Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл бүрээр 8 дугаар сарын 18-ны дотор нарийвчлан гаргаж, таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавжаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа, ургац хураалтын үед баримтлах технологийн ерөнхий зөвлөмжөөр тогтмол хангаж, ургац хураалтын мэдээ, тайланг үнэн зөв гаргах;</p> <p>3.11. Газар тариалангийн</p>	<p>3.6. Өөрийн аймгийн болон бусад аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, малчдадаа өөрийн хэрэгцээ болоод бизнесийн зориулалтаар хадлан хийх газрыг хуваарилан 21,1 мян.тн байгалийн хадлан бэлтгэсэн.</p> <p>3.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ онд шинээр барьж байгуулсан инженерийн хийцтэй 4 худгийн ажлыг Орхон, Шаамар, Түшиг, Баруунбүрэн сумдад хийсэн. Энэ ажилд явцын хяналт тавьж, ажлын хэсэг байгуулан хүлээн авсан.</p> <p>3.8. Малын тоо толгойн албан татвараар Орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн хөрөнгийг Мал аж ахуйн салбарын 12 чиглэлийн үйл ажиллагаанд захиран зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэлийг хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 10.0 мян татвар төлөгч малчин өрхийн 1,9 сая толгой мал хамрагдаж 1,806 сая төгрөгийн татварын орлогыг бүрдүүлэхээс оны эцэст 1,482 сая төгрөг төвлөрч, 503.9 сая төгрөг дутуу төвлөрүүлж, гүйцэтгэл 70 хувь байна.</p> <p>3.9. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ шуурхай авч хэрэгжүүлэх талаар нийт 5 удаагийн Зөвлөмж, чиглэлийг сумдад хүргүүлэн ажилласан.</p> <p>3.10. Ургацын урьдчилсан балансын дүнгээр үр тариа 132 мянган,га талбайгаас 202 мянган,тн, тэжээлийн ургамал 17.2 мянган,га талбайгаас 21.2 мянган,тн, тосны ургамал 53 мянган,га талбайгаас 29.2 мянган,тн, төмс 2.6 мянган,га талбайгаас 29.5 мянган,тн, хүнсний ногоо 4.2 мянган,га талбайгаас 53.6 мянган,тн хураан авахаар тогтоогдсон. 3.11. 10890 аж ахуй нэгж, иргэн, 6707 нэгж талбар, 312 мян,га талбай бүртгүүлсэн. улаан буудайн урамшуулалд 224 иргэн, аж ахуй нэгжид 6,7 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшуулалд 268 иргэн, аж ахуй нэгжид 1,5 тэрбум төгрөгийн урамшуулалд хамрагдсан. Үр тариа, төмс, хүнсний ногооны 4613 ширхэг гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосон байна.</p> <p>3.11 Газар тариалангийн нэгдсэн систем /plant.mofa.gov.mn/-д нийт 6834 нэгж талбарын 314658,3 га талбай бүртгэгдсэнээс 2023 оны ургацаас 9-12 сард 1396 иргэн, аж ахуйн нэгж улаанбуудай, хүнсний ногооны урамшууллын хүсэлт илгээгээд байна.</p> <p>3.12 9 сард орсон их хэмжээний үргэлжлэн орсон усархаг борооны улмаас аймгийн хэмжээнд ургац хураалтын ажил хойшлон 8 сарын сүүл, 9 сарын эхээр ангилсан тариа болон болц гүйцсэн улаанбуудайн түрүүндээ соёолж аймгийн хэмжээнд 28,1 мян, тн улаанбуудай гурилын үйлдвэрт тэнцэхээргүй болж тэжээлд шилжсэн бөгөөд 12 сарын 31-ны байдлаар 11 сумын 25 аж ахуй нэгж иргэдэд 5826 тн будаа хадгалагдаж</p>	
--	--	--	--	--

			<p>мэдээллийн нэгдсэн санд тариаланчид, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>3.12. Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;</p> <p>3.13. Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийх, дараа оны тариалалтад зориулан нөөцлөх үрийн цэвэрлэгээг шалгаж, стандарт шаардлагад нийцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ, ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад байнгын хяналт тавьж ажиллах;</p> <p>3.14. Төвлөрсөн хот, суурин газар, төв замын дагуу төмс, хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;</p>	<p>байна. Мөн ургац хураалтын ажил хойшилсонтой холбоотойгоор малчид намаржаандаа буух, мал намаржаа руу бэлчих тохиолдол ихсэн тариалангийн талбайд мал орж багагүй үр тариа болон тэжээлийн, тосны ургамлын ургацад хохирол учруулсан.</p> <p>3.13. Сортын хянан баталгааг 13 сумын 32 аж ахуйн нэгжийн 18970 га талбайн улаан буудайн ургацад 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 2023 оны 9 дүгээр сарын 02-ны өдрүүдэд ХХААГ-ын Газар тариалангийн албаны дарга бөгөөд ерөнхий агрономич Т.Шинэчимэг, мэргэжилтэн Ө.Билгүүн, Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Батболд нарын бүрэлдэхүүнтэйгээр хийхэд 13 сумын 34 иргэн, аж ахуйн нэгжийн 14693,3 га талбайн ургац тэнцсэн бөгөөд 1-р ангид 10395,2 га, 2-р ангид 3986,7 га, 3-р ангид 4596,7 га тэнцсэн, 4014 га талбай сорт холилдсоны улмаас тэнцээгүй байна.</p> <p>3.14 Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн "River garden" хороололд Алтанбулаг сумын "Хүчү агро" ХХК нь өөрийн нэрийн дэлгүүрээ нээж, "Алтан намрын шим" хоршооны худалдаа үйлчилгээний борлуулалтыг цэг байгуулахаар гэрэлтүүлэг, авто зогсоол, барилгын ажлыг эхлүүлж, 80 хувьтай хийгдэж, аймгийнхаа брэнд бүтээгдэхүүнийг худалдан борлуулахаар ажиллаж байна.</p>	
112	199	<p>"Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01</p>	<p>1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, "Эрдэнэс Монгол"</p>	<p>"Сэлэнгэ баялаг ирээдүй" орон нутгийн өмчийн оролцоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 34 сая төгрөг буюу 34 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан, Баруунбүрэн сумын иргэн Т.Данзандорж нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022 онд гараагүй. Ч.Хаш-Эрдэнэ захиралтай "Сэлэнгэ хаш баялаг" орон нутгийн өмчийн оролцоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20 сая төгрөг буюу 20 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Оюунболд нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022 онд гараагүй. Д.Бямбабазар</p>	100%

			ХХК-ны гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	захиралтай "Сэлэнгэ ресурс" орон нутгийн өмчийн оролцоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20сая төгрөг буюу 20 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан.нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022, 2023 онд гараагүй	
	200		1.5. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2022-2023 онд "Вектор мэл" ХХК гүйцэтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 18 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, сумын төв, суурин газрын 24 байршилд тэг гортигийг 32.4 мянган га газраар тэлж, томоохон суурин үүссэн, цаашид үүсэх 11 сумын 27 байршлын 11.4 мянган га газрыг хот тосгон бусад суурины ангиллаар төлөвлөн орон сууц, олон нийтийн бүс, нам давхрын орон сууцны үүргийн бүсчлэлийг сум тус бүрийн 0 гортигт багтаан төлөвлөсөн байна.	100%
	201		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан "5Ш ажиллагаа"-ны хүрээнд "Шил" ажиллагааг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд аймгийн албан ёсны цахим хуудсанд тогтоолыг хэрэгжүүлэх журмын хавсралтад заагдсан 6 зүйл 98 заалтын хэрэгжилтийг хангуулан shilen.gov.mn цахим хуудсанд 96,3 хувийн үзүүлэлттэй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.2.3-т заасны дагуу ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн бичмэл тайланд хамаарах бөгөөд 2023 оны 03 дугаар 01-ний дотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хэвлэмэл байдлаар хүргүүлсэн.	100%
113	202	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2023-07-25 Дугаар 2023_03	2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө, захирамж, удирдамж гарган хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах; 2.2. Нийт мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага	2.1. 2023-2024 оны өвөл хавар бэлчээрт 4196 инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг ашиглагдах бөгөөд худгийн бэлэн байдал 97,6 хувь, өрхийн усан хангамж 96,2 хувьтай байна. Аймгийн хэмжээнд мал өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг 92,8 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. 2.2. Аймгийн хэмжээнд 57,7 мян.толгой хонинд, 14.9 мян.толгой үхэр сүрэгт үзлэг хийж, ээмэглэж, бүртгэлжүүлэх ажлыг сумдын хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч болон аймагт үйл ажиллагаа эрхэлж буй мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран хийж гүйцэтгэсэн 2.3. Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж буй 4196 хуц, 2758 ухна нийт 6954 толгой бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийсэн. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоогоор 1993 бух, 4509 хуц, 3317 ухна дутагдаж	100%

			<p>хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>2.3. Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх;</p> <p>2.4. Мал, эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион байгуулах, хот суурин газарт нэвтрэх мал, мах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, зам дагуу байрлах орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;</p> <p>2.5. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь хийж гүйцэтгэх;</p> <p>2.6. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдал, зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;</p>	<p>байна.</p> <p>2.5 Өөрийн аймгийн болон бусад аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, малчдадаа өөрсдийн хэрэгцээний болон бизнесийн зориулалтаар хадлан хийх газрыг хуваарилан намрын технологит хугацаанд 21,1 мян.тн байгалийн хадлан бэлтгэсэн.</p> <p>2.6. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдал, зохион байгуулалтыг бүрэн хангуулж Үр тариа 128,1 мянга га талбайгаас 15,5 тн буюу 198,4 мян,тн, төмс 2,6 мян, га талбайгаас 127,9 цн буюу 32,7 мян, тн, хүнсний ногоо 4,8 мян,га талбайгаас 172,4 цн буюу 83,6 мян,тн тус тус хураан авсан байна.</p> <p>2.7. Малын тоо толгойн албан татвараар Орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн хөрөнгийг Мал аж ахуйн салбарын 12 чиглэлийн үйл ажиллагаанд захиран зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэлийг хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 10.0 мян татвар төлөгч малчин өрхийн 1,9 сая толгой мал хамрагдаж 1,806 сая төгрөгийн татварын орлогыг бүрдүүлэхээс оны эцэст 1,482 сая төгрөг төвлөрч, 503.9 сая төгрөг дутуу төвлөрүүлж, гүйцэтгэл 70 хувь байна. Сумдаас авсан зарцуулалтын дэлгэрэнгүй судалгаагаар бэлчээрийн усан хангамж нэмэгдүүлэх, Малын чанарыг сайжруулах, сургалт, сурталчилгааны зардалд энэ онд 910,3 сая төгрөгийн санхүүжилтийг мал аж ахуйн салбарт зарцууллаа.</p> <p>-Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 6 суманд 303 сая төгрөгөөр 8 худаг, булаг, шандын эх хамгаалах, худаг сэргээн засварласан.</p> <p>-Малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 9 суманд 236 сая төгрөгөөр мал угаалгын ванн, тарилгын хашаа хийсэн. 298 сая төгрөгөөр вакцин, автомат дүк, ковш авахаар төсөвлөсөн байна.</p> <p>-Малын чанарыг сайжруулах чиглэлээр 4 суманд 280 сая төгрөгөөр сайн чанарын хээлтүүлэгч Жавхланта хуц, Баянгол бух авч, Ерөө суманд нэг үржлийн нэгж байгуулсан.</p> <p>-Сургалт, сурталчилгааны чиглэлээр 51,4 сая төгрөгөөр малчдыг соён гэгээрүүлэх сургалт, зөвлөгөөн, туршлага судлах аялал хийсэн.</p> <p>2.8. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт 68,5 мян.мал бүхий 305 өрх өвөлжихөөр байна.</p> <p>2.9. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн 16 сумын 44 багийг тариалангийн бүс нутаг болгон зарласан. Үүнтэй холбогдуулан газар тариалангийн бүс нутагт бусад аймаг сумдаас мал оруулахгүй байх, гаднаас малтай айл өрх шилжин ирэхийг хориглож бусад аймаг сумдаас отроор мал өвөлжүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. Одоогоор отроор өвөлжихөөр</p>	
--	--	--	--	---	--

		<p>2.7. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавих;</p> <p>2.8. Бэлчээрийн даац, багтаамжид тулгуурлан аймаг, сум дундын отрын бүс нутаг, улсын хилийн зурвас болон байгалийн тусгай хамгаалалттай газар нутагт отроор өвөлжүүлэх малчин өрх, мал сүргийн тоог харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах, бүс алгасаж отор нүүдэл хийхгүй байхад анхаарах;</p> <p>2.9. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах;</p> <p>2.10. Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт отор нүүдэл хийх журмыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, мөрдөн ажиллах;</p>	<p>шилжин нүүсэн малчин өрх байхгүй байна.</p> <p>2.10. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн 16 сумын 44 багийг тариалангийн бүс нутаг болгон зарласан. Үүнтэй холбогдуулан газар тариалангийн бүс нутагт бусад аймаг сумдаас мал оруулахгүй байх, гаднаас малтай айл өрх шилжин ирэхийг хориглож бусад аймаг сумдаас отроор мал өвөлжүүлэхгүй байх чиглэлийг баримтлан ажиллаж байна.</p> <p>2023 оны 12 дугаар 31-ний байдлаар отроор өвөлжихөөр шилжилт хөдөлгөөн хийсэн малчин өрх байхгүй байна.</p>	
--	--	---	---	--